

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/2/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn Аудитор Г.Сампилмаа Утас: 261740 Цахим хаяг: sampilmaag@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал.....	12
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт	20
3.5.4 Нэмэлт төсөв	26
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	30
4.1 Ерөнхий зүйл	30
4.2 Материаллаг байдал.....	30
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	30
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	31
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	31
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	33
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	34
4.5.1 Завсрын аудитын талаар	34
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	34
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	34
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	36
5.1 Харьяа байгууллагууд.....	36
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч	36
5.2.1 Албан шаардлага.....	36
5.2.2 Зөвлөмж	37
5.3 Түүврийн байгууллага	39
5.3.1 Албан шаардлага	39
5.3.2 Зөвлөмж.....	40
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	42

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
БЦГХЗ	Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ДЦГХЗ	Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
ЗГНС	Засгийн газрын нөөц сан
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УТХГНХЗ	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
УЦУОСМХ	Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар
ЦУОШТ	Цаг уур орчны шинжилгээний төв
ЭАХБ	Эрхлэх асуудлын хүрээний байгууллага



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
Ц.САНДАГ-ОЧИР ТАНАА

2026.04.27 № 1150

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 31,813.6 сая төгрөгийн 151 алдаа, зөрчил илэрснээс 374.4 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 11,791.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 52 албан шаардлага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 14.4 сая төгрөгийн 3 албан шаардлагыг хүргүүлж, 19,633.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 65 зөвлөмжийг өгсөн ба өмнөх оноос зөрчлийн дүн 1.7 дахин өссөн байна.

Энэ нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 15 дугаар зүйлийн 15.1.5, Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.10, 42 дугаар зүйлийн 42.1, 42.5 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Бүгд Найрамдах Солонгос улсын Байгаль орчны яам, Байгаль орчны корпорацн хоорондын гэрээ хэлэлцээрийн үр дүнд “Монгол улсад агаарын чанарын автомат станцыг байгуулж, агаарын чанарын менежментийн чадавхыг сайжруулах”-аар буцалтгүй тусламжаар нийслэл, 21 аймгийн төвд мэдээллийн технологид суурилсан орчны агаарын чанарыг хянах автомат станцыг суурилуулах, чадавхыг бэхжүүлэхэд зориулж нийт 8.9 сая ам.долларын хөрөнгийг шийдвэрлэж, Цаг уур, орчны шинжилгээний газарт хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэсний байгууллагын Конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах зарим төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр яамны төсөвт батлагдаж, Нийслэлийн Засаг Даргын тамгын газарт эрх шилжүүлсэн, санхүүжилтийг тус яамаар дамжуулаагүй шууд олгосон нийт 49,759.8 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,678,364.8	201,752,817.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	53,434,458.5	58,712,535.5
33	АВЛАГА	2,418,586.6	7,226,016.1
34	УРЬДЧИЛГАА	19,096,000.5	17,469,987.1
35	БАРАА МАТЕРИАЛ	30,607,490.8	38,680,901.2
36	НӨӨЦИЙН БАРАА	30,708.3	17,541.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	56,091,120.1	79,645,836.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	122,427,445.9	127,410,646.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	122,427,445.9	127,410,646.2
39100	Газар	-	132,825.0
39200	Биет хөрөнгө	101,398,774.5	106,865,616.0
39300	Биет бус хөрөнгө	21,028,671.4	20,412,205.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	284,105,810.7	329,163,464.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	57,602,640.3	81,798,232.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	57,602,640.3	81,798,232.1
41300	Өглөг	49,325,142.3	77,525,818.9
41400	Урьдчилж орсон орлого	8,277,498.0	4,272,413.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	226,503,170.4	247,365,231.9
51	Засгийн газрын хувь оролцоо	226,503,170.4	247,365,231.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	45,249,731.4	45,249,731.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,910,927.9	7,924,279.5
51200	Хуримтлагдсан үр дүн	169,640,191.3	190,227,330.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,702,319.8	3,963,890.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	284,105,810.7	329,163,464.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	290,726,977.9	268,695,083.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,230,239.8	268,695,083.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	252,496,738.1	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	234,992,377.6	205,793,272.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,992,377.6	205,778,972.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,840,565.8	192,261,839.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,798,766.7	106,134,577.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,225,044.8	13,242,855.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,352,793.2	2,869,719.4
2104	Хангамж, бараа материалын зардал	3,848,017.5	3,614,727.7
2105	Нормативт зардал	320,425.0	295,207.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,837,546.4	1,382,977.8
2107	Томилолт, зочны зардал	1,873,674.4	1,649,876.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,849,266.6	46,935,235.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,735,031.2	16,136,662.1
212	ТАТААС	45,017.1	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,106,794.7	13,517,132.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	14,300.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	55,734,600.3	62,901,811.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,617.1	29,073.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	44,067,641.1	41,879,533.8
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(44,057,024.0)	(41,850,460.1)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	11,677,576.3	21,051,350.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	283,294,339.3	259,257,326.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,504,249.5	259,257,326.8
120	Нийтлэг татварын бус орлого	24,167,090.6	25,838,914.5
122	Тусламжийн орлого	4,337,158.9	233,418,412.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	254,790,089.8	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,466,235.8	189,568,163.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,466,235.8	189,568,163.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	209,249,144.8	169,964,224.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,879,982.7	105,861,161.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,373,373.8	13,387,144.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,383,404.7	2,926,188.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,955,369.6	1,804,172.7
2105	Нормативт зардал	219,531.9	241,183.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,835,126.0	1,928,984.9
2107	Томилолт, зочны зардал	1,765,607.5	1,629,084.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,090,793.6	41,689,839.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	745,955.0	496,465.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,217,091.0	19,603,939.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	44,828,103.5	69,689,163.4
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,002.4	16,573.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	29,676,213.1	64,427,916.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,676,213.1	64,427,916.4
2200	Дотоод эх үүсвэрээр	29,676,213.1	64,427,916.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(29,668,210.7)	(64,411,342.9)
14	Бусад эх үүсвэр	9,065.9	30,213.4
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	284,223.0	29,956.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(275,157.1)	256.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	14,884,735.7	5,278,077.0
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,549,722.8	53,434,458.5
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,434,458.5	58,712,535.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,636,442.7		213,636,442.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	973,919.6		973,919.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,610,362.3		214,610,362.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	152,153.2		152,153.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	87,248.0		87,248.0
Зарласан ногдол ашиг	(24,169.4)		(24,169.4)
Тайлант үеийн үр дүн	11,677,576.3		11,677,576.3
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,503,170.4		226,503,170.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(465,824.7)		(465,824.7)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,037,345.7		226,037,345.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	330,624.7		330,624.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(30,941.1)		(30,941.1)
Зарласан ногдол ашиг	(23,148.3)		(23,148.3)
Тайлант үеийн үр дүн	21,051,350.9		21,051,350.9
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,365,231.9		247,365,231.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	260,905,041,700.00	226,648,164,819.41	34,256,876,880.59	86.9
Татварын бус орлого	260,905,041,700.00	226,648,164,819.41	34,256,876,880.59	86.9
Нийтлэг татварын бус орлого	2,162,765,200.00	7,187,577,146.34	(5,024,811,946.34)	332.3
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	2,121,570,000.00	6,843,290,982.06	(4,721,720,982.06)	322.6
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	41,195,200.00	344,286,164.28	(303,090,964.28)	835.7
Тусламжийн орлого	258,742,276,500.00	219,460,587,673.07	39,281,688,826.93	84.8
Төсвөөс санхүүжих	258,742,276,500.00	219,460,587,673.07	39,281,688,826.93	84.8
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	260,905,041,700.00	221,723,511,700.00	39,181,530,000.00	85.0
УРСГАЛ ЗАРДАЛ	191,402,541,700.00	160,697,304,916.16	30,705,236,783.84	84.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,626,241,400.00	157,803,870,104.45	29,822,371,295.55	84.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,441,917,500.00	101,473,544,680.84	2,968,372,819.16	97.2
Үндсэн цалин	51,117,700,600.00	50,648,794,771.41	468,905,828.59	99.1
Нэмэгдэл	34,643,367,900.00	32,912,364,904.62	1,731,002,995.38	95.0
Унаа хоолны хөнгөлөлт	10,042,067,700.00	10,429,311,580.20	(387,243,880.20)	103.9
Урамшуулал	8,008,932,300.00	7,216,252,485.40	792,679,814.60	90.1
Гэрээт ажлын хөлс	629,849,000.00	266,820,939.21	363,028,060.79	42.4
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	13,357,281,600.00	12,788,793,337.31	568,488,262.69	95.7
Тэтгэврийн даатгал	9,141,077,100.00	8,696,915,331.08	444,161,768.92	95.1
Тэтгэмжийн даатгал	1,068,703,400.00	1,047,570,344.99	21,133,055.01	98.0
ҮОМШӨ-ний даатгал	546,879,700.00	539,356,073.72	7,523,626.28	98.6
Ажилгүйдлийн даатгал	521,205,900.00	501,357,602.17	19,848,297.83	96.2
Эрүүл мэндийн даатгал	2,079,415,500.00	2,003,593,985.35	75,821,514.65	96.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,006,131,800.00	2,727,500,028.76	278,631,771.24	90.7
Гэрэл, цахилгаан	1,193,798,800.00	1,072,355,966.33	121,442,833.67	89.8
Түлш, халаалт	1,202,556,200.00	1,144,652,830.23	57,903,369.77	95.2
Цэвэр, бохир ус	160,899,000.00	112,934,178.85	47,964,821.15	70.2

Байрны түрээс	448,877,800.00	397,557,053.35	51,320,746.65	88.6
Хангамж, бараа материалын зардал	1,460,953,500.00	1,127,383,237.31	333,570,262.69	77.2
Бичиг хэрэг	222,683,400.00	145,481,998.62	77,201,401.38	65.3
Тээвэр, шатахуун	485,567,200.00	472,876,871.60	12,690,328.40	97.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	436,218,800.00	296,912,341.91	139,306,458.09	68.1
Ном, хэвлэл	10,123,900.00	11,003,500.00	(879,600.00)	108.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,774,500.00	41,911,557.00	47,862,943.00	46.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	216,585,700.00	159,196,968.18	57,388,731.82	73.5
Нормативт зардал	356,542,800.00	236,563,518.00	119,979,282.00	66.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	152,357,500.00	128,167,558.00	24,189,942.00	84.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	204,185,300.00	108,395,960.00	95,789,340.00	53.1
Эд хогшил, урсгал засварын зардал	1,990,571,300.00	1,741,192,217.79	249,379,082.21	87.5
Багаж, техник, хэрэгсэл	976,429,600.00	838,006,552.88	138,423,047.12	85.8
Тавилга	3,400,000.00	3,395,250.00	4,750.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	136,219,500.00	54,362,444.00	81,857,056.00	39.9
Урсгал засвар	874,522,200.00	845,427,970.91	29,094,229.09	96.7
Томилолт, зочны зардал	1,215,958,800.00	1,060,849,106.30	155,109,693.70	87.2
Гадаад албан томилолт	703,365,300.00	610,370,583.60	92,994,716.40	86.8
Дотоод албан томилолт	512,593,500.00	450,478,522.70	62,114,977.30	87.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,523,905,300.00	36,385,455,901.63	25,138,449,398.37	59.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	60,674,889,500.00	35,979,334,209.68	24,695,555,290.32	59.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	69,124,100.00	20,966,240.00	48,157,860.00	30.3
Даатгалын үйлчилгээ	104,517,000.00	43,138,610.00	61,378,390.00	41.3
Тээврийн хэрэгслийн татвар	52,643,500.00	36,495,236.00	16,148,264.00	69.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	17,447,100.00	9,556,118.96	7,890,981.04	54.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	426,970,600.00	212,187,683.99	214,782,916.01	49.7
Газрын төлбөр	133,342,100.00	71,086,903.00	62,255,197.00	53.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,880,600.00	119,200.00	7,761,400.00	1.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх	37,090,800.00	12,571,700.00	24,519,100.00	33.9
Бараа үйлчилгээний бусад зардал	272,978,800.00	262,588,076.51	10,390,723.49	96.2
Бараа үйлчилгээний бусад зардал	127,706,100.00	121,631,244.51	6,074,855.49	95.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	145,272,700.00	140,956,832.00	4,315,868.00	97.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,776,300,300.00	2,893,434,811.71	882,865,488.29	76.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	153,526,800.00	5,163,062.00	148,363,738.00	3.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	153,526,800.00	5,163,062.00	148,363,738.00	3.4
Бусад урсгал шилжүүлэг	3,622,773,500.00	2,888,271,749.71	734,501,750.29	79.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	673,310,800.00	176,155,200.00	497,155,600.00	26.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146,570,200.00	109,700,000.00	36,870,200.00	74.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,723,295,100.00	2,595,189,749.71	128,105,350.29	95.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	79,597,400.00	7,226,800.00	72,370,600.00	9.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,502,500,000.00	61,026,206,783.84	8,476,293,216.16	87.8
Барилга байгууламж	63,787,600,000.00	55,714,184,095.84	8,073,415,904.16	87.3
Их засвар	2,957,800,000.00	2,554,978,908.00	402,821,092.00	86.4
Тоног төхөөрөмж	2,757,100,000.00	2,757,043,780.00	56,220.00	100.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	4,924,653,119.41	(4,924,653,119.41)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	87	87	-	100.0
Төсвийн байгууллага	87	87	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	2915	2898	17	99.1
Удирдах ажилтан	149	131	18	87.9
Гүйцэтгэх ажилтан	2427	2432	5	100.2
Үйлчлэх ажилтан	339	335	4	98.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		8,567,522,598.41
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		8,567,522,598.41
Тусламжийн орлого		8,567,522,598.41
Хандив тусламж /дотоод/		8,567,522,598.41
Нэмэлт санхүүжилтийн орлого		8,567,522,598.41
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,741,731,384.89
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		85,654,772.78
ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,520,214,735.12
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,852,627,265.52
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,367,294,440.10
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,777,979,972.79
УРСГАЛ ЗАРДАЛ		7,752,847,292.79
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,737,860,067.69
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,607,671,919.49
Үндсэн цалин		729,786,020.42
Нэмэгдэл		2,232,158,835.87
Унаа хоолны хөнгөлөлт		35,988,139.45
Урамшуулал		609,738,923.75
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		443,446,913.22
Тэтгэврийн даатгал		347,083,123.99
Тэтгэмжийн даатгал		23,669,697.64
ҮОМШӨ-ний даатгал		16,875,231.45
Ажилгүйдлийн даатгал		8,919,662.45
Эрүүл мэндийн даатгал		46,899,197.69
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		48,345,466.44
Гэрэл, цахилгаан		14,444,479.25
Түлш, халаалт		6,117,705.19
Цэвэр, бохир ус		10,143,282.00
Байрны түрээс		17,640,000.00
Хангамж, бараа материалын зардал		510,743,798.61
Бичиг хэрэг		37,716,040.00
Тээвэр, шатахуун		366,556,573.64
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		46,129,781.97
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		17,246,380.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		43,095,023.00
Нормативт зардал		4,619,500.00
Хоол, хүнс		4,419,500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		200,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		428,848,049.11
Багаж, техник, хэрэгсэл		198,522,200.00
Тавилга		54,465,135.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,270,060.00
Урсгал засвар		173,590,654.11
Томилолт, зочны зардал		567,999,689.00
Гадаад албан томилолт		66,295,353.00
Дотоод албан томилолт		486,704,336.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		15,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,959,134,561.82
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,939,636,456.82

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		800,000.00
Даатгалын үйлчилгээ		6,026,000.00
Тээврийн хэрэгслийн татвар		5,539,847.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		112,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		134,000.00
Газрын төлбөр		6,885,758.00
Бараа үйлчилгээний бусад зардал		167,050,170.00
Бараа үйлчилгээний бусад зардал		107,592,300.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		59,457,870.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		14,987,225.10
Бусад урсгал шилжүүлэг		14,987,225.10
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		200,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		14,787,225.10
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		25,132,680.00
Дотоод эх үүсвэрээр		25,132,680.00
Тоног төхөөрөмж		14,300,000.00
Бусад хөрөнгө		10,832,680.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		789,542,625.62

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 169 дүгээр “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зарим яамд байгуулах тухай” зарлигаар Байгаль орчныг хамгаалах яамыг анх байгуулсан байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь эрхэм зорилгоо “Байгаль хамгаалах нэгдмэл удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн нөөц, баялгийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамжтай үндэсний нийгэм, эдийн засгийн ногоон хөгжлийн загварыг бий болгоно.” гэж тодорхойлжээ.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа нийт 93 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Усны газар, Цаг уур орчны шинжилгээний газар түүний харьяа байгууллага 26;
- Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа 35;
- Усны сав газрын захиргаа 21;
- Байгаль орчны судалгаа шинжилгээний төв, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв, Монгол Кувейтийн байгаль хамгаалах судалгааны төв ТӨААТҮГ;
- Яамны хөрөнгө оруулалт, Нөхөн сэргээлтийн данс;
- Татан буугдах шийдвэр гарсан Аялал жуулчлалын хөгжлийн төв, Аялал жуулчлалын үндэсний төв, Монгол-Ус ТӨААТҮГ, Байгаль орчин, уур амьсгалын сангийн ажлын алба.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Агаарын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хуулийг үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлд мөрдөж байна.

Тус яам нь доор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

1. Монгол Улсад хүрээлэн байгаа орчны тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан тодорхойлж төлөвлөх, хэрэгжүүлэх;
2. Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор чиглүүлэх;
3. Яам, салбарын албан хаагчдыг байгаль орчныг хамгаалах, ногоон технологийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход шинжлэх ухааны ололт, олон улсын сайн туршлага, стандарт, бүтээмжийн арга хэрэгслийг нэвтрүүлэх, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
4. Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах;
5. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын бодлого, хууль тогтоомж, стандарт, нормын шинэчлэл, зохицуулалтыг хэрэгжүүлэх.

Тайлант онд Улсын Их Хурал, Засгийн газраас шинээр баталсан тогтоол болон бусад журам, албан даалгаврыг мөрдөж ажилласан байна. Тухайлбал:

1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг мөрдсөн;
2. Засгийн газрын 2025 оны 36 дугаар тогтоолоор “Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажиллах дүрэм, ажлын албаны бүтэц, орон тоо, чиг үүрэг, төсөв, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө”-г баталж, мөрдөж эхэлсэн;
3. Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т нэгтгэсэн;
4. Засгийн газрын 2025 оны 171 дүгээр тогтоолоор “Байгаль орчин, уур амьсгалын сангийн ажлын алба”-ыг татан буулгаж, чиг үүргийг тус яаманд шилжүүлсэн;
5. Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар”-ыг мөрдөж ажилласан;
6. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/38 дугаар тушаалаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж, мөрдөж ажилласан байна.

Тайлант онд дотоод аудитын нэгжээс төлөвлөгөөт 13 сэдвээр, төлөвлөгөөт бус 1 сэдвээр дотоод аудитыг гүйцэтгэж, давхардсан тоогоор 17 алба, нэгжид, нийт 148 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснээс, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 37, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 36, нийт 73 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг 100.0 хувьтай биелүүлсэн гэж дүгнэсэн байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлж, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,032.6 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	53,434.5	58,687.5	5,253.0

АВЛАГА	2,418.6	7,226.0	4,807.4
УРЬДЧИЛГАА	19,096.0	17,470.0	(1,626.0)
БАРАА МАТЕРИАЛ	30,607.5	38,680.9	8,073.4
НӨӨЦИЙН БАРАА	30.7	17.6	(13.1)
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	56,091.1	79,645.8	23,554.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	122,427.4	127,410.6	4,983.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	284,105.8	329,138.4	45,032.6
ӨР ТӨЛБӨР	57,602.6	81,798.2	24,195.6
Засгийн газрын хувь оролцоо	226,503.2	247,340.2	20,837.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	284,105.8	329,138.4	45,032.6

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 58,687.5 сая төгрөг болж, өмнөх оноос 5,253.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	2.0	1.8	(0.2)
Төгрөг	2.0	1.8	(0.2)
Банканд байгаа бэлэн мөнгө	53,432.4	58,685.7	5,253.3
Төрийн сангийн харилцах	51,633.1	57,070.1	5,437.0
Арилжааны банк дахь харилцах	1,799.3	1,615.6	(183.7)
Дүн	53,434.5	58,687.5	5,253.0

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,253.0 сая төгрөгөөр өссөн нь ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгчид нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50.0 хувь буюу 9,809.3 сая төгрөгийн нөхөн сэргээх баталгааг байршуулсан, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл I /KFW/-ийн хүрээнд хэрэгжүүлсэн “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн Төрийн банканд байршуулсан эх үүсвэрийн үлдэгдэл 1,075.5 сая төгрөгийг данс бүртгэлд тусгасан зэргээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Татварын и-баримт цахим системд 266.0 сая төгрөгийн төлбөрийн баримтыг дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан;
- Усны газар: Тайлант онд 5 харилцагчийн 12.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй;
- Говь-Алтай аймгийн УЦУОШТ: Тайлант онд шилдэг ажилтан, албан хаагч шалгаруулж 8.2 сая төгрөгийн шагналыг цалингийн сангаас олгосон;
- Дорноговь аймгийн УЦУОШТ: Тайлант онд байгууллагын албан хаагчдын нэгдсэн сургалтыг Хилэнц ресортод зохион байгуулж, заалны түрээсийн төлбөрт 0.5 сая төгрөгийг зарцуулсан, мөн 6 ажилтанд цалинтай чөлөөтэй байх хугацаанд 1.2 сая төгрөгийн цалингийн нэмэгдлийг олгосон, 3 ажилтны 7.3 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй;
- Өмнөговь аймгийн УЦУОШТ: Байгууллагын шилдэг ажилтнаар шалгарсан 4 албан хаагчид цалингийн сангаас 2.3 сая төгрөгийн шагналыг олгосон;
- Дорнод аймгийн УЦУОШТ: Цалинтай чөлөө олгосон албан хаагчдад 2.2 сая төгрөгийн цалингийн нэмэгдлийг, 0.07 сая төгрөгөөр амралтын цалинг тус тус илүү тооцож олгосон;
- Дундговь аймгийн УЦУОШТ: Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчид улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал 1.5 сая төгрөгийг олгосон;
- Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдлийн 1.4 сая төгрөгийг эрхгүй ажилтанд олгосон;
- Орхон аймгийн УЦУОШТ: Шуудан холбооны зардлаас 1.0 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг төлсөн;
- Хөвсгөл аймгийн УЦУОШТ: Байгууллагад ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний дагуу олгосон 0.7 сая төгрөгийн ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, төлөөгүй;
- Дархан-Уул аймгийн УЦУОШТ: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдлийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохируулаагүй нийт 0.4 сая төгрөгийг илүү олгосон;
- Булган аймгийн УЦУОШТ: Цаг агаарт зориудаар нөлөөлөх үүл буудах экспедицийг хариуцан ажилласан инженерээс бусад 6 инженерт үндсэн цалингийн 10.0-20.0 хувиар тооцож, ажилласан хугацаанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгосон;
- Ховд аймгийн УЦУОШТ: Албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэхдээ ижил зэрэглэлтэй албан тушаалын үндсэн цалинг ялгаатай тогтоосон;

- Ойн газар: Тайлант онд тус газрын батлагдсан орон тооноос хэтрүүлэн модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хөлсөөр ажиллуулах гэрээг 21 иргэнтэй байгуулж цалинд 259.2 сая төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 27.9 сая төгрөгийг тус тус ойжуулалт хөтөлбөрийн зардлаас зарцуулсан;
- Ойн газраас БОУАӨЯ-ны албан хаагчдын болон гэрээт ажилчдын томилолтын зардалд 37.3 сая төгрөгийг, томилолтын тушаалгүй 1.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан, томилолтоор ажилласан 62 албан хаагчдад хоол унааны хөнгөлөлтийн 1.8 сая төгрөгийг илүү, 1.0 сая төгрөгийг дутуу тооцож олгосон;
- Ойн газар: БОУАӨС-ын Б/01, А/251, Ойн газрын даргын А/285, А/75 тушаалаар гадаад томилолтоор ажилласан албан хаагчдын томилолтын зардлын 13.0 сая төгрөгийн баримтын бүрдэл дутуу;
- Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны зарим ажилтнуудын гадаад томилолтын зардалд Усны газраас 2 албан хаагчийн 16.4 сая төгрөгийг, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-аас 4 ажилтны 24.2 сая төгрөгийг, нийт 40.6 төгрөгийг зарцуулсан бөгөөд анхан шатны баримт бүрдэлгүй, томилолтын тайлангүй;
- Тайлант онд цалин болон гэрээт ажил үйлчилгээний төлбөрөөс нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг Ойн газар 1.3 сая төгрөг, Усны газар 6.2 сая төгрөг, нийт 7.5 сая төгрөгийг суутган тооцоогүй;
- Усны газар: Тайлант онд 129 харилцагчид үйлчилгээ үзүүлсний орлогын төлбөрийн баримтыг 50.4 сая төгрөгөөр дутуу, 112 харилцагчид 125.9 сая төгрөгийн төлбөрийн баримтыг илүү шивж олгосон;
- Усны газар: БОУАӨС-ын 2025 оны А/71 тоот тушаалыг үндэслэн 2025 оны 2 дугаар сараас 13 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдэл олгох хувь, хэмжээг нэмэгдүүлэн нийт 3.2 сая төгрөгийг олгохдоо байгууллагын даргын тушаал шийдвэрийг тухайн хугацаанд гаргаагүй, 12 дугаар сард нөхөн гаргасан;
- Усны газар: Тайлант онд 1 жолоочийг 2 өөр аймагт, ижил хугацаанд ажилласнаар баримтыг бүрдүүлж томилолтын олговорт 2.7 сая төгрөг, мөн 2 албан хаагчийн буудлын төлбөрт 0.5 сая төгрөг, нийт 3.2 сая төгрөгийг илүү тооцож олгосон.
- Дэлгэрмөрөн-Шиххэд голын сав газрын захиргаа: Албан хаагчдад ажил хавсран ажилласны нэмэгдлийг ажлын ачаалал, гүйцэтгэл үр дүнг харгалзахгүй 40.0 хувиар тогтоож нийт 23.8 сая төгрөгийг олгосон;
- Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа: Байгууллагын батлагдсан орон тооноос илүү 2 хүн ажиллуулж нийт 8.0 сая төгрөгийн цалинг олгосон;
- Нөмрөгийн ДЦГХЗ: БОАЖС-ын 2023 оны Б/03 дугаар тушаалаар томилогдсон тус байгууллагын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь төрийн жинхэнэ албан хаагч биш боловч нэмэгдэл цалинг тооцож 4.3 сая төгрөгийг олгосон, томилолтоор ажилласан 2 ажилтны томилолтын нөхөн олговрыг тус бүр 1 хоног илүү тооцон 0.4 сая төгрөгийг олгосон;
- Сэлэнгэ голын сав газрын захиргаа: Тайлант онд ээлжийн амралтаа биеэр эдлээгүй албан хаагчдад үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн олгохоор үндэслэлгүй тушаал гаргаж нийт 3.2 сая төгрөгийг, мөн байгууллагын удирдлага тушаал шийдвэргүй 1.6 сая төгрөгийн цалинг илүү тооцож тус тус олгосон;
- Орхоны хөндийн БЦГХЗ: Төрийн үйлчилгээний албан хаагчдад бүх нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс болон илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсаар баталгаажуулаагүй 1.4 сая төгрөгийг олгосон;
- Орхон-Чулуут голын сав газрын захиргаа: Батлагдсан бүтэц, орон тоонд тусгагдаагүй ажлыг хавсран гүйцэтгүүлж нэмэгдэл цалин олгосон, нэр бүхий 3 албан хаагчийн албан томилолтыг анхан шатны баримтаас илүү тооцож 0.3 сая төгрөг, 1 албан хаагчид цалин хөлсийг зөрүүтэй тооцож 0.4 сая төгрөг, нийт 0.7 сая төгрөгийг илүү олгосон.

3.4.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 7,226.0 сая төгрөг болж, өмнөх оноос 4,807.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	78.3	77.0	(1.3)
Татаас, санхүүжилтийн авлага	966.8	3,348.0	2,381.2
Дансны авлага /ТӨҮГ/	29.7	29.7	-
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	4.8	14.0	9.2
Байгууллагаас авах авлага	1,235.7	3,651.7	2,416.0
Хувь хүмүүсээс авах авлага	103.2	105.6	2.4
Дүн	2,418.6	7,226.0	4,807.4

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь Сангийн сайдын 2026 оны 24 дүгээр тушаалаар төсвийн байгууллагын 2025 оны төсвийн жилийн үйл ажиллагааны давсан орлогоос харьяа 59 байгууллагад нийт 4,848.5 сая төгрөгийг олгохоор хуваарилж, авлагад бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлага дансны үлдэгдэлд 3 жилээс дээш насжилттай тус яамны 299.7 сая төгрөгийн, Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 4.0 сая төгрөгийн, нийт 303.7 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй;

- Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ 153.7 сая төгрөгийн, Ойн газар 141.2 сая төгрөгийн, нийт 294.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй;
- БОУАӨЯ: Авлагын УЦҮОСМХ-ээс авах 50.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй боловч тус байгууллагад яаманд төлөх өглөгийн үлдэгдэл байхгүй;
- Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн хамгаалалтын захиргаа: Тайлант онд 6.9 сая төгрөгийн татварын авлага үүсгэсэн;
- Хэрлэн голын сав газрын захиргаа Өмнөх онд үүссэн татварын авлагын 1.1 сая төгрөг, Хануй голын сав газрын захиргаа ажилтнуудтай холбоотой 0.1 сая төгрөг, нийт 1.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 17,470.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,626.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	18,188.9	16,562.9	(1,626.0)
Урьдчилгаа тооцоо	907.1	907.1	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	907.1	907.1	-
Дүн	19,096.0	17,470.0	(1,626.0)

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 17,470.0 сая төгрөг болж буурахад Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс өмнөх онуудад хэрэгжүүлсэн 1,193.6 сая төгрөгийн отоглох цэг барих ажлыг хүлээн авч, тайлант онд зардалд хүлээн зөвшөөрсөн нь голлон нөлөөлсөн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 38,680.9 сая төгрөг болж, өмнөх оноос 8,073.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт (-)
Түүхий эд материал	14,088.3	14,982.0	893.7
Дуусаагүй үйлдвэрлэл	7,338.7	13,937.0	6,598.3
Бэлэн бүтээгдэхүүн	2.6	449.6	447.0
Хангамжийн материал	9,010.5	9,090.2	79.7
Биологийн хөрөнгө	22.2	24.8	2.6
Мал амьтад	145.2	197.3	52.1
Дүн	30,607.5	38,680.9	8,073.4

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 8,073.4 сая төгрөгөөр өссөн нь Ойн газраас Шинэ Хархорум хотын ногоон бүсэд байгуулсан хашаа, хамгаалалтын 7,121.4 сая төгрөг, усалгааны систем, худгийн 4,998.7 сая төгрөг, нийт 12,120.1 сая төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн гэр хорооллын 5012 өрхийг 4 квт цахилгаан халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх Багц: 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12 эрчим хүчний ажлын, мөн аймгуудын Дулааны цахилгаан станцын шүүлтүүр суурилуулах болон зуухны яндангийн утааны шүүлтүүр, цонхны шүүлтүүр нано тор, газрын гүний дулааны насос, нам даралтын зуухыг хийн зуухаар солих, аймгуудын нам даралтын зуухны утаа шүүгч зэрэг нийт 33,096.6 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг холбогдох баримтыг үндэслэн, ашиглагч байгууллагуудад шилжүүлсэн байна.

Мөн Дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим аймгийн Дулааны цахилгаан станцад шүүлтүүр суурилуулах, хийн халаагуур, төвийн дулааны шугам сүлжээний ажил, бараа, үйлчилгээний нийт 5,522.5 сая төгрөгийг холбогдох баримтыг үндэслэн ашиглагч талуудад шилжүүлж, ЦУОШГ-аас харьяа 25 байгууллагад 3,247.9 сая төгрөгийн тусгай зориулалтын материал болон цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицэд борооны пуужинг олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- БОУАӨЯ: Дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2020-2021 онд нэр бүхий 6 аймгийн сум болон Нийслэлийн Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын 1,386.8 сая төгрөг, лаг шатаах үйлдвэрийн 406.1 сая төгрөг, нийт 1,792.9 сая төгрөгийн дуусаагүй ажлын үлдэгдэлтэй, гэрээний хугацаа дууссан боловч гэрээт ажлыг дуусгуулах арга хэмжээ авч ажиллаагүй;
- Ойн газар: Ойн газрын даргын А/232 тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн 17947 ширхэг 144.6 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалыг зарлагадахдаа 16.5 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагдсан;
- Дорноговь аймгийн УЦУОШТ: Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 12 нэр төрлийн 32 ширхэг нийт 332.8 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн;
- Хөх сэрхийн нурууны УТХГХ-ын захиргаа: Бараа материалын тайланг батлагдсан маягтаар сар бүр гаргуулж тооцоо хийгээгүй, орлого зарлагын дүн зөрүүтэй;
- Их газрын чулууны БЦГХ-ын захиргаа: Үнэт цаасны тооллого хийж баталгаажуулаагүй, хяналт хангалтгүй байна.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 79,645.8 сая төгрөг болж, өмнөх оноос 23,554.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	56,015.1	79,645.8	23,630.7
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	76.0	-	(76.0)
Дүн	56,091.1	79,645.8	23,554.7

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 23,554.7 сая төгрөгөөр өсөхөд Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах зарим төсөл арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Нийслэлийн ЗДТГ-т эрх шилжүүлсэн нийт 49,759.8 сая төгрөгийг бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 127,410.6 сая төгрөг болж, өмнөх оноос 4,983.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Газар	-	132.8	132.8
Биет хөрөнгө	101,398.7	106,865.6	5,466.9
Барилга, байгууламж, орон сууц	54,418.0	54,115.7	(302.3)
Авто-тээврийн хэрэгсэл	15,106.1	17,871.3	2,765.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,159.1	27,095.8	2,936.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,115.3	2,295.3	180.0
Зам, гүүрний байгууламж	1,860.5	1,684.7	(175.8)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	0.3	0.2	(0.1)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,210.8	1,210.8	-
Бусад үндсэн хөрөнгө	2,520.3	2,583.5	63.2
Ном	8.3	8.3	-
Биет бус хөрөнгө	21,028.7	20,412.2	(616.5)
Программ хангамж	558.0	540.6	(17.4)
Бусад биет бус хөрөнгө	20,470.7	19,871.6	(599.1)
Дүн	122,427.4	127,410.6	4,983.2

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өсөхөд ТӨБЗГ-ын 2025 оны 374, 432, 813 дугаар тогтоолоор харьяа 39 байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3077 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 5,991.1 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,757.0 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авсан, харьяа байгууллагуудын барилгын их засварт 2,555.0 сая төгрөгийг зарцуулж, капиталжуулан бүртгэсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөд дараах томоохон өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

1. ТӨБЗГ-ын 2025 оны 374 дүгээр тогтоолоор тус яамны харьяа 11 байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 245 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 716.1 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон;
2. ТӨБЗГ-ын 2025 оны 432 дугаар тогтоолоор тус яамны харьяа 13 байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 724 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 1,137.2 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон;
3. ТӨБЗГ-ын 2025 оны 813 дугаар тогтоолоор тус яамны харьяа 39 байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2108 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 4,137.8 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон;
4. ТӨБЗГ-ын 2025 оны 382 дугаар тогтоолоор яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 483.2 сая төгрөгийн балансын үнэ, 356.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 4 ширхэг автомашиныг харьяа 4 байгууллагад балансаас баланст шилжүүлсэн;
5. ТӨБЗГ-ын 2025 оны 437 дугаар тогтоолоор тус яамны харьяа 3 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16 нэрийн 102.5 сая төгрөгийн балансын үнэ, 92.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг харьяа 6 байгууллагад балансаас баланст шилжүүлсэн;
6. ТӨБЗГ-ын 2025 оны 826 дугаар тогтоолоор тус яамны харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 82 нэрийн, нийт 889.5 сая төгрөгийн балансын үнэ, 520.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг харьяа 7 байгууллага болон ССАЖЗЯ, Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн цэргийн 0257, 0133 дугаар анги, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газарт балансаас баланст шилжүүлсэн;
7. ТӨБЗГ-ын 2025 оны 828 дугаар тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 99 нэрийн, нийт 5,108.1 сая төгрөгийн балансын үнэ, 748.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг, 113.8 сая төгрөгийн бараа материалыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлсэн;
8. ТӨБЗГ-ын 2025 оны 837 дугаар тогтоолоор тус яамны харьяа 26 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 650.4 сая төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 33 нэрийн тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг 129.9 сая төгрөгөөр тогтоосон;
9. ТӨБЗГ-ын 2025 оны 401 дүгээр тогтоолоор тус яамны харьяа 17 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй 195 нэрийн 415.5 сая төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан;
10. ТӨБЗГ-ын 2025 оны 457 дугаар тогтоолоор Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 19 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй 682 нэрийн 641.5 сая төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан;
11. ТӨБЗГ-ын 2025 оны 858 дүгээр тогтоолоор тус яамны харьяа 44 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй 982 нэрийн 2,477.0 сая төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй хөрөнгийг акталж, данснаас хассан;
12. ТӨБЗГ-ын 2025 оны 861 дүгээр тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 506 нэрийн, нийт 3.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг, 4.7 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан.

Аудитын илрүүлэлт:

- Ойн газар: Хандиваар хүлээн авсан бараа материалын дансанд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинж чанартай 39 ширхэг 52.9 сая төгрөгийн хөрөнгийг тушаал шийдвэргүй шууд зарлагдсан;
- Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа: Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор 192.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 3.9 сая төгрөгийн бараа материал дутуу тоологдсон;
- Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэр төрлийн хөрөнгийг актлах, цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй;
- Онги-Таац голын сав газрын захиргаа: Үндсэн хөрөнгийн тайланд 20.0 сая төгрөгийн орлогын баримт, 8.0 сая төгрөгийн зарлагын баримт дутуу хөтөлсөн;
- БОУАӨЯ: Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй худгийн байшин 3 ширхэг, газар доорх зоорь, гүний худаг, емкость, техникийн байшин, ариун цэврийн байгууламж зэрэг 10 нэр төрлийн 503.3 сая төгрөгийн хөрөнгө хаана байгаа нь тодорхойгүй, жилийн эцсийн тооллогоор биетээр тоологдоогүй;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар Богдхан уулын дархан цаазат газрын Нүхтийн амны хязгаарлалтын бүсэд байрлах 3.9 га буюу 39000 м.кв газрыг "Цөлжилттэй тэмцэх

Монгол-Хятадын хамтын ажиллагааны төв"-ийг байгуулах зорилгоор ашиглах эрхийг тус яаманд олгосон боловч данс бүртгэлд тусгаагүй;

- Баянхонгор аймгийн УЦУОШТ: Тус байгууллагын эзэмшлийн 13 газрын 46158 м.кв газрыг данс бүртгэлд тусгаагүй;
- Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа: Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 10,000.0 м.кв хэмжээтэй, 6409013284 нэгж талбарын дугаар бүхий газрыг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулаагүй;
- Монгол кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын барилга байгууламж байршиж буй шинжилгээ, судалгааны чиглэлээр ашиглаж байгаа Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний амны хязгаарлалтын бүсэд байрлах нийт 3.5 га газрыг ашиглах эрхийн гэрчилгээ нь "Богдхан уулын Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны нэр дээр бүртгэлтэй" гэх боловч ашиглах хугацаа дууссан, сунгуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй;
- Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа: Тус байгууллагын эзэмшлийн Рэнчинлхүмбэ сумын нутагт байрлах 400 м.кв талбайтай, 0.8 сая төгрөгийн суурь үнэлгээтэй газрын гэрчилгээтэй боловч данс бүртгэлд болон улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд бүртгэлгүй;
- Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, 27.4 сая төгрөгийн анхны өртөгтэй 14 нэр төрлийн 15 ширхэг хөрөнгийг актлах, цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй;
- БОУАӨЯ: Өмнөх онуудад Хьюндай Соната-7 маркийн 22-28 УБУ дугаартай 32.4 сая төгрөгийн балансын үнэтэй, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн, үлдэх өртөггүй автомашиныг акталж дуудлага худалдаагаар зарсан гэх боловч данс, бүртгэлээс хасаагүй байна.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 81,798.2 сая төгрөг болж, өмнөх оноос 24,195.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Өглөг	49,325.1	77,525.8	28,200.7
Ажилчидтай холбогдсон өглөг	183.1	429.2	246.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	25.9	210.8	184.9
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	2,574.1	2,535.2	(38.9)
Бусад өглөг	46,542.0	74,350.6	27,808.6
Урьдчилж орсон орлого	8,277.5	4,272.4	(4,005.1)
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	6,149.8	3,796.6	(2,353.2)
Бусад урьдчилж орсон орлого	2,127.7	475.8	(1,651.9)
Дүн	57,602.6	81,798.2	24,195.6

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өсөхөд санхүүжилтийн эх үүсвэр дутагдсантай холбоотой гэрээт ажлыг хугацаандаа гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн боловч зарим санхүүжилтийг олгоогүй өглөгт бүртгэсэн, ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгчид нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50.0 хувь буюу 9,809.3 сая төгрөгийн нөхөн сэргээх баталгааг байршуулсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Монгол кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ: Өмнөх онуудад болон тайлант онд үссэн цахилгааны болон НДШ, татварын өрийг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй 771.4 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй;
- БОУАӨЯ: Байгууллагад төлөх өглөгийн дансанд хөрөнгө бэлтгэхтэй холбоотой нэр бүхий 6 төрийн байгууллагын нийт 312.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба өглөгийн тооцоог нийлж, барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй;
- БОУАӨЯ: Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2022 онд Могойн гол, Шарын гол нүүрсний уурхайг түшиглэн Завхан аймагт "Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр" байгуулахаар төлөвлөж Завхан аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-06, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-37 дугаартай гэрээг тус тус байгуулсан боловч дээрх үйлдвэрийг байгуулаагүй, барьцааны дансанд 200.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Тайлант оны эцэст өглөгийн дансанд бүртгэлтэй 531.6 сая төгрөгийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй;
- Ойн газар: Тайлант оны эцэст 16,000.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэйгээс 155.8 сая төгрөгийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй;
- Тайлант оны жилийн эцсийн тайлангаар харилцагч байгууллагуудад Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа 66.2 сая төгрөгийн, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 17.8 сая төгрөгийн, Онон-Улз голын сав газрын захиргаа 9.3 сая төгрөгийн, Дэлгэрмөрөн-Шиххэд голын сав газрын захиргаа 7.7 сая төгрөгийн, Алтайн өвөр говийн сав газрын захиргаа

4.9 сая төгрөгийн, Булган аймгийн УЦУОШТ 3.0 сая төгрөгийн, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа 1.6 сая төгрөгийн, нийт 110.5 сая төгрөгийн өр төлбөртэй;

- Усны газар: Тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтны 3 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн тэтгэмжийн зардал болох 4.6 сая төгрөгийг олгоогүй боловч санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй;
- Дорноговь аймгийн УЦУОШТ: Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, үйлдвэрчний эвлэлийн холбооны хураамжийн нийт 0.5 сая төгрөгийн өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардалд бүртгэсэн байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 247,365.2 сая төгрөг болж, өмнөх оноос 20,862.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	45,249.7	45,249.7	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,910.9	7,924.3	13.4
Хуримтлагдсан үр дүн	169,640.2	190,227.3	20,587.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,702.3	3,963.9	261.6
Дүн	226,503.2	247,365.2	20,862.1

Эх сурвалж: БОУАӨС-ын ЭАХБ-дын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 247,365.2 сая төгрөг болж өсөхөд тайлант үеийн үр дүн 16,552.8 сая төгрөгийн үзүүлэлттэй гарсан нь голлон нөлөөлжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр тус яамны өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний барьцаа баталгааны 5.0 хувийг давхардуулан бүртгэснийг буцаан залруулсан 429.1 сая төгрөг, Ховд аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төвийн өмнөх оны элэгдлийн зөрүүг залруулсан 36.7 сая төгрөг, нийт 465.8 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

БОУАӨС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны нэгтгэсэн төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 400,429.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,332.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тооцож, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн саналыг хянан урсгал зардлыг 23.4 хувиар бууруулж, нийт 308,571.6 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны тодотголоор бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 31,433.6 сая төгрөгөөр, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,866.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,039.3 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 11,327.3 сая төгрөгөөр, нийт 47,666.6 сая төгрөгөөр буюу 15.4 хувиар бууруулж 260,905.0 сая төгрөгөөр тодотгосон байна.

Дээрх тодотголоор Ойжуулалт хөтөлбөрийн зардлыг 18,180.9 сая төгрөгөөр, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зардлыг 4,497.0 сая төгрөгөөр, Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн зардлыг 511.2 сая төгрөгөөр, Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөр буюу Мазаалай, нэн ховор амьтад хамгаалах зардлыг 484.6 сая төгрөгөөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн зардлыг 8.1 сая төгрөгөөр, харьяа байгууллагуудын урсгал зардлыг 12,829.2 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 11,327.3 сая төгрөгөөр, нийт 47,838.3 сая төгрөгөөр бууруулж, Усны нөөц гол мөрний менежмент хөтөлбөрийн зардлыг 171.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 63,316.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 219,460.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 7,187.6 сая төгрөгийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээний зардалд 157,803.9 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 2,893.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 61,026.2 сая төгрөгийг зарцуулж, 4,924.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 221,723.5 сая төгрөг буюу 85.0 хувьтай байгаа нь бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн баталсны дагуу харьяа 81 байгууллага нь 301 орон тоог бууруулсантай холбоотой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,536.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 25,138.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 8,476.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан зэргээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Усны газар: Усны нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрт 44 харилцагчид 9,266.7 сая төгрөгийн төлбөр ногдуулснаас 8,656.5 сая төгрөгийг төлөөгүй, усны нөөц ашигласны төлбөрийг 308 байгууллагад 119,814.4 сая төгрөгийн ногдуулалт хийснээс 22,708.2 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, 7 байгууллагын 238.6 сая төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, 43 байгууллагын гэрээг дүгнээгүй байхад дараа оны тооцоолол хийж ногдуулалт гарган холбогдох журмыг зөрчсөн;
- Усны газар: Ус бохирдуулсны төлбөрт 252 дүгнэлтээр 11,121.1 сая төгрөгийн төлбөр тооцоолж, 9,124.6 сая төгрөгийг чөлөөлж, 105 харилцагчийн 327.5 сая төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, төлбөрийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй;
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс Усны газар үйл ажиллагааны орлого 82.7 хувь буюу 671.2 сая төгрөгөөр давж биелсэн, Төв аймгийн УЦУОШТ үйл ажиллагааны орлогоос 0.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 22.7 сая төгрөгийн орлогыг бүдүүлж, нийт 693.8 сая төгрөгөөр давсан;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Тайлант онд эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 1,434.4 сая төгрөгөөр буюу 35.0 хувиар тасалсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;
- Нөмрөгийн ДЦГХЗ: 510.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 325.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 185.0 сая төгрөг буюу 36.3 хувиар тасалсан;
- Мянган угалзатын БЦГХЗ: Үнэт цаасны орлогыг дутуу төвлөрүүлж, үлдэгдлийн тооллогоор 1.2 төгрөгийн үнэт цаас дутсан;
- Ойн газар: БОУАӨС-ын 2025 оны А/890 тушаалаар Шинэ Хархорум хотын ногоон бүсэд хөрсний судалгаа хийх, ногоон бүсэд ойн зурвас байгуулахад 18,682.0 сая төгрөгийн төсөв баталсан боловч Шинэ Хархорум хотын ногоон бүсэд хашаа, хамгаалалт байгуулахад 7,121.4 сая төгрөгийг, усалгааны систем худаг байгуулахад 4,998.7 сая төгрөгийг, төрийн далбаа мандуулах төмөр шон тээвэрлэн суурилуулах ажилд 10.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Төвийн захирлын тушаалаар байгууллагын дүрэмд дүн шинжилгээ хийж, төсөл боловсруулах, цалин хөлсний журам, хөдөлмөрийн сахилга, гомдол гаргах, ажлын эцсийн үр дүн, хүлээх хариуцлага, гэрээг дүгнэх журам, эд хөрөнгийн хохирол нөхөн төлүүлэх журам, ажилтны мэдээллийг авах, боловсруулах хадгалах ашиглах журам боловсруулах, Монгол кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ыг холбоотой дүрэм, бүтэц, албан тушаалын жагсаалт, боловсруулах ..., гэх мэт зардалд нийт 148.7 сая төгрөгийг ажлын даалгавар, харьцуулалтын судалгаагүй, ирүүлсэн үнийн саналгүй, гэрээ дүгнэсэн актгүй шууд гэрээ байгуулж олгосон;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Тус төвийн захирал 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар 31-нийг хүртэлх хугацаанд байгууллагын харилцах данснаас нийт 0.5 сая төгрөгийн зарлагын 50 удаагийн гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, ямар нэг хяналтгүй хийж гүйцэтгэсэн;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Ажилд эгүүлэн тогтоолгох, нөхөн олговор олгох маргаантай шүүх хуралд ажил олгогчийн өмнөөс өмгөөлөгчөөр оролцох зардалд 29.0 сая төгрөгийг шууд гэрээ байгуулан ажлын даалгавар, харьцуулсан үнийн саналгүй, гэрээ дүгнэсэн актгүй олгосон;
- БОУАӨЯ: Гадаад томилолтын зардлаас гаднын байгууллагын ажилтны томилолт, тийзийн төлбөрт нийт 135.1 сая төгрөгийг зарцуулсан;
- БОУАӨЯ: Тус яамны нэр бүхий 1 албан хаагчийн хувийн харилцах дансанд "Өндөр түвшний зэрэгцээ арга хэмжээний зохион байгуулалтын зардал" гэх 82.1 сая төгрөгийг шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу, Арабын Нэгдсэн Эмират, Катар улсад томилолтоор ажилласан нэр бүхий 3 албан хаагчийн тийзийн төлбөрийг давхардуулан 42.9 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, сайдын орон тооны бус зөвлөх 1 хүний гадаад томилолтын зардалд 5.1 сая төгрөг, нийт 130.1 сая төгрөгийг олгосон;
- БОУАӨЯ: Сэлгэн ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд цалингийн зөрүүг олгох зорилгоор холбогдох тушаал шийдвэргүй нууцын нэмэгдлийг 9-11 сар хүртэл 3.1 сая төгрөг, 12 сард ээлжийн амралт биеэр эдлээгүйд тооцож 1.0 сая төгрөг, нийт 4.1 сая төгрөгийг олгосон;
- БОУАӨЯ: Нэр бүхий 8 ажилтан гадаад томилолтоор ажиллаж 67.3 сая төгрөгийг зарцуулсан боловч ажлаас чөлөөлөгдөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан;
- Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа: Байгууллагын 1 ажилтныг холбогдох тушаал шийдвэргүй ээлжийн амралттай байх хугацаанд 9 хоног томилолтоор ажиллуулан 1.5 сая төгрөгийг олгосон;

- Алтайн өвөр говийн сав газрын захиргаа: Тайлант онд албан хаагчдыг томилолтоор ажиллах үед хоолны хөнгөлөлтийг давхардуулан 1.3 сая төгрөгийг олгосон;
- Хөгнө Тарны БЦГХЗ: Тайлант онд 1 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндэслэл, шийдвэргүй нэмэгдүүлэн 1.1 сая төгрөгийг олгосон;
- Зэд-Хантай-Бүтээлийн нурууны ДЦГХЗ: Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг холбогдох шийдвэргүй 5 албан хаагчид анхан шатны баримтгүй 0.7 сая төгрөгийг илүү, 4 албан хаагчид анхан шатны баримтгүй 0.3 сая төгрөгийг дутуу олгосон;
- Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа: Ахмад настнуудыг амралтад хүргэж өгөх ажлаар Говьсүмбэр-Улаанбаатар-Ойн булаг амралтын хооронд 6 удаа явсан гэх жолоочийн тооцооны хуудас нь хариуцаж явсан, явахыг зөвшөөрсөн дарга нягтлан бодогч нарын гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулж, тооцоо бодсон актгүй 0.7 сая төгрөгийг зарцуулсан;
- Хөх сэрхийн нурууны УТХГХЗ: Тайлант онд 1 албан хаагчид ээлжийн амралтын цалин 0.5 сая төгрөгийг давхардуулан олгосон;
- Увс нуурын ай савын УТХГХЗ: Тайлант оны 8 дугаар сарын цахилгааны төлбөрийн үлдэгдэл 0.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бэлнээр төлсөн;
- Хөвсгөлийн УТХГХЗ: Байгалийн цогцолборт газарт нэвтрэх хог хаягдлын хураамжийн орлогоос анхан шатны баримтгүй 0.4 сая төгрөгийг зарцуулсан;
- Тэсийн гол, Булнайн нурууны БЦГХЗ: Тус байгууллагын нягтлан бодогч нь Хөвсгөлийн УТХГХ-ын захиргааны нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг бөгөөд 2025 онд санхүүгийн тайланд аудит хийлгэхээр ажилласан томилолтыг 1 хоног, яаманд тайлан нэгтгүүлэхээр ажилласан томилолтыг 1 хоног тус тус давхардуулж, нийт 0.4 сая төгрөгийг илүү тооцож олгосон;
- Монгол элсний УТХГХЗ: Байгууллагын 1 ажилтанд 8, 9 дүгээр сард нийт 2 хоногийн амралт цалин давхардуулан тооцож 0.2 сая төгрөгийг илүү олгосон;
- Дорнод ДЦГХЗ, Буйр нуур Мэнэнгийн сав газрын захиргаа: УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолоор "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Д/д	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
	Нийт дүн	260,905.0	221,723.5	39,181.5	85.0
71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	76,992.3	67,858.8	9,133.5	88.1
71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	3,488.2	2,143.8	1,344.4	61.5
71407	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	5,010.6	1,669.5	3,341.1	33.3
71403	Ойжуулалт	49,846.9	33,490.4	16,356.5	67.2
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	32,986.3	30,422.0	2,564.4	92.2
71408	Ус цаг уур, орчны шинжилгээ	75,894.5	74,408.6	1,485.9	98.0
71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	14,847.8	11,623.5	3,224.3	78.3
71412	Хүрээлэн буй орчны судалгаа, шинжилгээ	1,838.4	106.9	1,731.6	5.8

Эх сурвалж: БОУАӨЯ-ны 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

БОУАӨС-ын 2025 оны А/700, 702, 707 дугаар тушаалаар тайлант онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн хүрээнд урсгал төсвөөс нийт 9,552.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 9 төсөл арга хэмжээнд 4,094.6 сая төгрөгийг;
- Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 12 төсөл арга хэмжээнд 3,468.0 сая төгрөгийг;
- Хүрээлэн буй орчны судалгаа, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 19 төсөл арга хэмжээнд 1,989.7 сая төгрөгийг зарцуулахаар баталсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын 1.4.5-д “төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх” гэж заасны дагуу Агаар, орчны бохирдлыг бууруулах, Мазаалай баавгайг хамгаалах, Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх, Ойжуулалт хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй ба 2025 онд санхүүжилтийн нийт 23,427.9 сая төгрөгийг олгоогүй, дараагийн төсвийн жилд шилжүүлсэн байна.

3.5.3 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан тус Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 7 хөтөлбөр арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

ТЭЗ	Хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлтийн дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	2025 оны хүрсэн түвшин
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД									
71403 Ойжуулалт									
22.1	22.1.1	Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлын үр дүн, чанарыг сайжруулж, мод тарьж ургуулахад мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	22.1.1.1	Ойжуулж, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ	мян.га	2022	7.1	7.9	13
			22.1.1.2	Худалдан авсан таримал ой	мян.га	2022	-	20	0
			22.1.1.3	Дэмжлэг авсан мод үржүүлгийн газар	мян.шир	2022	10	50	0
	22.1.2	Ойн хөнөөлт шавжийн голомттой ойн санд тэмцлийн ажил явуулж, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж хомсдол, доройтлыг бууруулж, ойн төлөв байдлыг үнэлсэн байна.	22.1.2.1	Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн талбай	мян.га	2022	165	230	247.3
			22.1.2.2	Ойн хөнөөлт шавжийн судалгаа хийсэн талбай	сая.га	2022	2	2	2.48
			22.1.2.3	Ой зохион байгуулалтын ажил хийгдсэн талбай	сая.га	2022	1.6	5	1.5
			22.1.2.4	Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажил хийсэн талбай	хувь	2022	5	5	5
	22.1.3	Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, 4000 га-д ойн арчилгаа, 3000 га-д цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	22.1.3.1	Ойн төлөв байдлыг сайжруулах арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээ хэрэгжүүлсэн талбай	мян.га	2022	0.3	4	5
			22.1.3.2	Хяналт шалгалт хийх	тоо	2022	6	15	20
	71410 Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх								
22.2	22.2.1	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон 2000 га талбайд стандартын дагуу нөхөн сэргээлт хийсэн байна.	22.2.1.1	Биологийн нөхөн сэргээлт хийсэн жишиг талбай	га	2022	773	1000	464
			22.2.1.2	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	га	2022	2189	2500	1713
			22.2.1.3	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, хяналтын тооллого зохион байгуулсан талбай	га	2022	8000	8000<	42076
	22.2.2	Цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэл бүхий аймгуудын нутагт газрын доройтлыг	22.2.2.1	Байгалийн ургамлыг нөхөн сэргээж, тарималжуулсан талбайн хэмжээ	га	2022	50	100	70

		бууруулах, нөхөн сэргээх, элсний нүүлтийг сааруулах арга хэмжээг 200 га талбайд хэрэгжүүлсэн байна.	22.2.2.2	Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, зурвас байгуулсан талбайн хэмжээ	га	2022	10	50	35	
			22.2.2.3	Бэлчээрийн талбайг хашиж хамгаалан, ургамлын нөмрөгийг нөхөн сэргээсэн талбайн хэмжээ	га	2022	-	50	0	
		71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент								
22.3	22.3.1	Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв цөөрөм шинээр барих, сэргээн засварласан байна.	22.3.1.1	Шинээр барьсан хөв цөөрөм	тоо	2022		7	4	
			22.3.1.2	Эх, ундаргыг нь хамгаалсан горхи, булаг шанд	тоо	2021	2936	3900	328	
	22.3.2	Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн болон үйлдвэрлэлийн усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж, усны нөөцийг тогтоож, баталгаажуулсан байна.	22.3.2.1	Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоосон хот, суурин газар	тоо	2022	1	5	4	
			22.3.2.2	Гидрогеологийн дунд масштаб /1:20000/-ын зураглал хийсэн талбай	хувь	2022	15.3	17	17.8	
			22.3.2.3	Рашааны ордын нөөцийн дахин үнэлгээ хийсэн орд	тоо	2022	2	4	1	
	22.3.3	Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалж, гадаргын болон газрын доорх усны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлсэн байна.	22.3.3.1	Туул голын хурдсыг цэвэрлэсэн хэмжээ	км	2022	-	5	0	
			22.3.3.2	Ус бохирдуулагчийн тоо /тооллогын мэдээ, тайлан/	тоо	2022	-	320<	309	
			22.3.3.3	Хяналт шинжилгээний цооног	тоо	2022	309	344	345	
			22.3.3.4	Урсгал засвар хийсэн газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног	тоо	2022	0	50	16	
			71405 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт							
22.4	22.4.1	Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 23 хувьд хүргэж, сүлжээг өргөжүүлсэн байна.	22.4.1.1	Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	хувь	2022	21	23	20.8	
			22.4.1.2	Тусгай хамгаалалтад авахаар судалгаа хийсэн газар нутгийн хэмжээ	мян.га	2022	600	600	3,2	
			22.4.1.3	Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үнэ цэн, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа	тоо	2022	1	2	2	
	22.4.2	Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчныг шинэчилж, олон талын оролцоотой	22.4.2.1	Аялал жуулчлалын нөөц, даацыг тодорхойлох судалгаа хийсэн тусгай	тоо	2022	10	10	10	

		хамгааллын менежментийг хэрэгжүүлж, чадавхыг бэхжүүлсэн байна.		хамгаалалттай газар						
			22.4.2.2	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн тусгай хамгаалалттай газар	тоо	2022	11	12	12	
			22.4.2.3	Хамгааллын менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа тусгай хамгаалалттай газар	тоо	2022	4	5	7	
71412 Хүрээлэн байгаа орчны судалгаа, шинжилгээ										
22.5	22.5.1	Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчилсэн байна.	22.5.1.1	Судалгаа хийсэн ургамал газарзүйн тойргийн тоо, нөөц тогтоосон ургамлын зүйл	тойргийн зүйлийн тоо	2022	150/2	300/7	2868,65	
			22.5.1.2	Олон улсын улаан дансны үнэлгээгээр үнэлсэн ургамлын зүйл	тоо	2022	500	1500	1500	
			22.5.1.3	Экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоосон ургамлын зүйл	тоо	2022	2500	3000	3000	
			22.5.1.4	Нөөц тогтоосон амьтны зүйлийн тоо	тоо	2022	2	2	2	
	22.5.2	Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, генийн санг хадгалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	22.5.2.1	Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн нэн ховор, ховор амьтан, ургамал	тоо	2022	5	4 /ургамал 2, амьтан 2/	4	
			22.5.2.2	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт	хувь	2022	28	40	45.15	
			22.5.2.3	Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэлжүүлэх чадавхжуулах сургалтад хамрагдсан хүн	хүний тоо	2022	80	100<	100	
			22.5.2.4	Харь зүйлийн эрсдэлийн үнэлгээ хийсэн тайлан	тайлан	2019	1	1	1	
	71406 Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтол									
	22.6	22.6.1	Орчны чанар, төлөв байдал, бохирдолд нөлөөлөх хүчин зүйлийн иж бүрэн судалгааг хийж, бохирдлын эрсдэлийг бууруулсан байна.	22.6.1.1	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж	мкг/м³	2022	41	31	37
22.6.1.2				Агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулсан аймаг, суурин	ширхэг	2022	2	5	21	
22.6.1.3				Бохирдол өндөртэй голуудад хийсэн цэвэрлэгээний ажлын хэмжээ	км	2022	T	30	45	

		22.6.1.4	Хөвсгөл нуурын бохирдлын эрсдэлийг бууруулах ажлын гүйцэтгэл	хувь	2022	40	70	75	
		22.6.1.5	Хөрсний нянгийн бохирдлын судалгаа	мян.км ²	2022	T	4.7	4,7	
22.6.2	Байгальд ээлтэй, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар бүх төрлийн эх үүсвэрээс ялгарах, бохирдуулах бодисын хаягдал, ялгарлыг бууруулна.	22.6.2.1	Шинээр барьсан аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах	тоо	2022	16	21	0	
		22.6.2.2	Эко тэмдэг, ногоон гэрчилгээ олгож, дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага	тоо	2022	16	36	31	
		22.6.2.3	Ногоон зээл авсан зээлдэгч /иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/	тоо	2022	700	1000<	0	
71408 Ус цаг уур, орчны шинжилгээ									
22.7	22.7.1	Цаг агаарын урьдчилсан мэдээний чанарыг сайжруулна.	22.7.1.1	Цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилан илрүүлэлт	хувь	2022	88.7	89	89
			22.7.1.2	Цаг агаарын урьдчилсан мэдээ	хувь	2022	87.5	88.3	88.3
			22.7.1.3	Ус, цаг агаар, хөдөө аж ахуйн цаг уур, орчны шинжилгээний бүх төрлийн мэдээллийг интернэтийн сүлжээгээр тогтоосон хугацаанд бүрэн дамжуулах	хувь	2022	30.3	100	100
	22.7.2	Цаг уурын бүх өртөө, харуулыг интернэтийн сүлжээнд холбох, цаг агаарын мэдээллийг дамжуулахад үүрэн холбооны систем ашиглалтыг нэмэгдүүлсэн байна.	22.7.2.1	Автомат хэмжих хэрэгслээр хэмжсэн цаг агаарын мэдээллийг 1 минут тутам төв серверт дамжуулах өртөө харуулын эзлэх хувь	хувь	2022	T	100	100
	22.7.3	Ажиглалт хэмжлийн цэгийн нягтаршил нэмэгдэж мэдээний цуваа уртасна. Шинээр байгуулагдах өртөө, харуулд хийгдэх цаг уурын үндсэн үзүүлэлтийн хэмжилтийн тоо нэмэгдэнэ.	22.7.3.1	Монгол Улсын хэмжээнд ургамлын ургалт, бэлчээрийн даац багтаамжийн мониторинг хийх	тоо	2022	1	1	1
			22.7.3.2	Монгол Улсын хэмжээнд гангын эрсдэлийн зураглал хийх	тоо	2022	1	1	1

Дээрх зорилтот түвшнийг хэрэгжүүлэхээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 7 арга хэмжээг хэрэгжүүлээгүй нь санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтайгаас голлон шалтгаалжээ.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайланг гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 8,567.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 7,778.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 789.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 8,567.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 2,741.7 сая төгрөгийг;
- Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр 85.7 сая төгрөгийг;
- ЗГНС, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 2,520.2 сая төгрөгийг;
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 1,852.6 сая төгрөгийг;
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,367.3 сая төгрөг.

Нэмэлт санхүүжилтээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын зардалд 4,051.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 1,959.1 сая төгрөг, томилолт зочны зардалд 568.0 сая төгрөг, бараа материалын зардалд 510.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 428.8 сая төгрөг, бусад зардалд 260.3 сая төгрөг, нийт 7,778.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгаль орчны салбарын харьяа зарим байгууллагад засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас төсөл хэрэгжүүлэх болон олон улсын бага хурал зохион байгуулахаар нэмэлт санхүүжилтийг хүлээн авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, гадаадын их, дээд сургууль, хүрээлэн зэрэг 10 байгууллагаас авсан хандиваар 1,327.4 сая төгрөгийг, 1 төсвийн байгууллага болон 3 ТӨХХК-тай байгуулсан гэрээний дагуу 87.8 сая төгрөгийг, нийт 1,415.2 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, 1,241.0 сая төгрөгийг зарцуулсан;

Мөн Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах зардлын санхүүжилтэд 785.9 сая төгрөгийг хүлээн авч, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд шинээр хэрэгжүүлэх 64,783.5 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг, өмнөх оноос шилжих 4,719.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг, нийт 69,502.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг баталсан байна.

Үүнээс Төрийн худалдан авах ажиллагааны газарт 14,783.5 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт 50,000.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тус тус эрх шилжүүлжээ.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын 4 барилга байгууламжийн их засварын ажилд 2,126.7 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр 1,694.7 сая төгрөгийг олгожээ.

Мөн салбарын сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, байгаль хамгаалагч, цаг уурын мэдээлэл авах ажилтны мотоцикл, компьютер, техник хэрэгслийн худалдан авалтад нийт 2,757.0 сая төгрөг батлагдаж, хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр холбогдох байгууллагад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт, их засварын ажилд нийт 59,899.8 сая төгрөгийг баталснаас, гүйцэтгэлээр 54,557.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Нийслэлийн ЗДТГ-т эрх шилжүүлсэн НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд нийт 50,000.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр 49,759.8 сая төгрөгийг олгосон;
- Усны газрын гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах 12 төсөл арга хэмжээнд нийт 6,478.9 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр 4 төсөл арга хэмжээнд 3,408.6 сая төгрөгийг олгосон;

- ЦУОШГ-ын орон нутаг дахь өртөө, харуул, байгаль хамгаалагчийн байр барих 4 багц төсөл арга хэмжээнд 2,589.7 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр 558.2 сая төгрөгийг олгосон;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын 5 барилга байгууламжийн их засварын 831.2 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр 830.5 сая төгрөгийг олгосон.

Аудитын илрүүлэлт:

- БОУАӨЯ: Увс аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор аймгийг зорин ирэх иргэд, жуулчдын ая тухыг хангах зорилгоор Увс аймгийн Засаг даргаас ариун цэврийн байгууламж, зөөврийн эко жорлон авахад зориулж 600.0 сая төгрөгийн дэмжлэг хүссэн боловч төсвийн төсөлд тусгаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй зөөврийн ариун цэврийн байгууламж авах тендерийг зарлаж, Оффроад трэйвэл ХХК 4 удаа шалгарч 150.0-500.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, нийт 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас олгосон, мөн Оффроад трэйвэл ХХК нь чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах, гэрээний үнийн дүнгийн 5.0 хувь буюу 50.0 сая төгрөгийн барьцааг байршуулаагүй;
- БОУАӨЯ: Газрын доройтол, цөлжилтийг бууруулах хөтөлбөрийн зардлаас судалгаа болон харьцуулалтгүй онгоцны тийзийн үйлчилгээ, зуучлан борлуулдаг 6 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулж, тийзийн төлбөрт 429.4 сая төгрөгийг олгосон, гадаад томилолтоор Арабын Нэгдсэн Эмират, Катар ажилласан 14 ажилтны тийзийн төлбөрт 147.5 сая төгрөгийг судалгаа болон харьцуулалтгүй "Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг" Тапа Трип Эжэнси ХХК-д шилжүүлсэн;
- БОУАӨЯ: Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/231 дүгээр тушаалаар ойжуулалтын хөтөлбөрөөс "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг олон нийтэд сурталчлах ажилд 4 телевиз, 29 сайтад нийт 349.9 сая төгрөгийг олгохоор баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр ойжуулалтын хөтөлбөрөөс 226.1 сая төгрөг, газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрөөс 58.6 сая төгрөг, нийт 284.7 сая төгрөгийг олгосон;
- БОУАӨЯ: Гүрэн ньюс медиа групп ХХК, Гэрэл плас медиа холдинг ХХК, Таурус ХХК зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага нь гэрээний нийт санхүүжилтийн 70.0 хувь буюу 55.8 сая төгрөгийг авсан боловч гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй;
- БОУАӨЯ: Үндэсний хорооны ажлын албаны /СОР 17/ урсгал зардлаас тендер сонгон шалгаруулалтгүй 30.3 сая төгрөгийн зөөврийн компьютер, принтер, 26.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 56.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан;
- БОУАӨЯ: Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд төсөвт тусгагдаагүй, тооцоо судалгаагүй "Хашаандаа 5 мод тарья" аяныг зохион байгуулахад нийт 5,000.0 сая төгрөгийг зарцуулахаар баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 265 аж ахуйн нэгжтэй мод тарих, 10 аж ахуйн нэгжтэй хяналт тавих, 7 аж ахуйн нэгжтэй сургалт зохион байгуулах 16.0-18 сая төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэл гараагүй байхад гэрээний нийт дүнгийн 70.0 хувь буюу 3,507.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, мөн гүйцэтгэлээр 308.2 сая төгрөгийн санхүүжилт авсан нэр бүхий 25 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн;
- Усны газар: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээг 660.1 сая төгрөгөөр илүү тусгасан;
- Усны газар: Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 693.9 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 35.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг тус тус шууд худалдан авалт хийсэн;
- Усны газар: Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулсан 1 төсөл арга хэмжээний 1,123.0 сая төгрөгийн гэрээг байгуулснаас 9 хоногийн дараа гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг байршуулсан, мөн 1 төсөл арга хэмжээний 465.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа 14.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй;
- Ойн газар: Ойн газрын даргын А/136 тушаалаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсаас санхүүжилт татах зорилгоор төсөл бичиж боловсруулах ажлын төлбөрийг 15.0 сая төгрөгөөр баталж, ажлын гэрээг 16.7 сая төгрөгөөр буюу 1.7 сая төгрөгийн илүү дүнгээр байгуулсан.

3.5.6 Ерөнхий чиглэлийн судалгааны үр дүн

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/685, 686, 687, 688, 690, 691, 692 дугаар тушаалаар эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн баталсны дагуу бүтцэд өөрчлөлт оруулан, харьяа 81 байгууллага нийт 287 орон тоог бууруулснаас 78 удирдах ажилтан, 209 гүйцэтгэх ажилтныг цомхотгосон байна.

"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг олон нийтэд сурталчлах ажилд 4 телевиз, 29 сайтад нийт 349.9 сая төгрөгийг олгохоор баталж, 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 314.4 сая төгрөгийг олгосон байна. Сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллага цахим сурталчилгаа, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 9.6 сая төгрөгийг олгосон байна.

Тайлант онд яамны харьяа 21 байгууллага 147 удаа эрдэм шинжилгээний бага хурал, зөвлөгөөн зохион байгуулж нийт 93.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой харьяа 3 байгууллагын ажлаас халагдсан 3 алба хаагчид төсвөөс нийт 41.5 сая төгрөгийг олгосон. Үүнээс 2 байгууллага нь 17.3 сая төгрөгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэхээр авлага үүсгэн бүртгэснээс 6.0 сая төгрөгийг төлүүлсэн байна.

Тус яам, түүний харьяа байгууллагуудын албан хаагчдад нийслэлд өдөрт хоолны хөнгөлөлт 15.0-34.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 3.0-10.0 мянган төгрөг, аймгийн төвд хоолны хөнгөлөлт 10.0-20.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 3.0-15.0 мянган төгрөг, сумын төвд хоолны хөнгөлөлт 5.0-15.0 мянган төгрөгөөр тооцож, тайлант онд нийт 10,429.3 сая төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтөд зарцуулсан байна.

Тайлант онд гадаад томилолтын зардалд төсвөөс 913.2 сая төгрөг, төслөөс 18.5 сая төгрөг, нийт 937.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал:

- Тус яамны хөтөлбөрийн зардлаас 24 удаагийн гадаад томилолтын зардалд 328.1 сая төгрөг, тийзийн төлбөрт 576.9 сая төгрөг, нийт 905.0 сая төгрөг;
- Цаг уур, орчны шинжилгээний газар болон БНСУ-ын Цаг уурын газар хоорондын хамтын ажиллагааны уулзалт, хамтарсан судалгааны ажлаар 3 удаагийн гадаад томилолтын зардалд, төсвөөс 8.2 сая төгрөг, төслөөс 18.5 сая төгрөг, нийт 26.7 сая төгрөг.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, байгууллагын өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхийн гэрчилгээг авах, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй мэдээлэх, арилжааны банканд байршуулсан санхүүжилтийн эх үүсвэрийн нийт үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, данс бүртгэлд бүрэн тусгах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өмнөх онуудад татан буулгах шийдвэр гарсан төрийн өмчит хуулийн этгээдийн хаалтын баланс гаргах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулах зэрэг өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитор Г.Сампилмаа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, дараагийн шатны чанарын хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 03/1907 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь сонгосон суурь үзүүлэлтээс 1.0 хувиар тооцож 2,791.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд урсгал болон захиргааны зардлыг, цахим шилжилт хийж цаасны хэрэглээг тус тус бууруулах, худалдан авах ажиллагаа, төсвийн сахилга батыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч ажилласан ба салбарын хэмжээнд 3202 орон тоотой байснаас 2915 орон тоотой болж цалин хөлсний болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,536.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- БОУАӨЯ: Үндэсний хорооны ажлын алба нь урсгал төсвөөс Бүгд Найрамдах Кени улсын Найроби хотноо зохион байгуулсан гадаад арга хэмжээний бэлэг дурсгалын зардалд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1.7 сая төгрөгийг зарцуулсан;
- БОУАӨЯ: Тус яамны үндсэн хөрөнгөд бүртгэлгүй 2 ширхэг суудлын автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж шатахууны зардалд 5.1 сая төгрөг, мөн яамны албан хэрэгцээнд Богдхан уулын ДЦГХЗ-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй "Toyota Land Cruiser J300" маркийн, 1754 УНС улсын дугаартай автомашиныг ашиглаж шатахууны зардалд 3.5 сая төгрөг, нийт 8.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Тайлант онд хүнс, чихэр, хоол, жимс, печень зэргийг 6.4 сая төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй хэмнэлтгүй зарцуулсан;

- Ойн газар: Газрын даргын А/83, А/92 тушаалаар жүжиг, дуу бүтээх контентын санхүүжилтэд 31.8 сая төгрөгийг, мөн тушаал шийдвэргүйгээр цай кофены зардалд 6.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Отгонтэнгэрийн УТХГХЗ: Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж 0.2 сая төгрөгийг зарцуулсан;
- Алтайн өвөр говийн сав газрын захиргаа: Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад волейболын хослол 0.7 сая төгрөгөөр худалдан авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмж өглөө.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитаар нийт 19,278.1 сая төгрөгийн 47 алдаа зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 15,144.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлага, 4,132.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг өгсөн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Түүврийн аудитад хамрагдсан зарим байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, нийт 477.0 сая төгрөгийн алдаа илрүүлж, аудитын явцад засуулсан. Үүнд:

1. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 256.2 сая төгрөгийн 18 гүйлгээ, бусад 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож байршуулсан;
2. Байгаль орчин судалгаа шинжилгээний төв нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 142.3 сая төгрөгийн 8 гүйлгээ, бусад 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож байршуулсан;
3. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 78.5 сая төгрөгийн 14 гүйлгээ, бусад 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Албан шаардлага

Илрүүлэлт: 1. Туул голын сав газрын захиргаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 339.0 сая төгрөгийн 7 гүйлгээ болон бусад 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Илрүүлэлт: 2. Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,125.5 сая төгрөгийн 18 гүйлгээ, зарлагын 101.9 сая төгрөгийн 13 мэдээлэл, бусад 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Аудитын илрүүлэлт:

- Усны газар: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18.7 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээг, 1,132.6 сая төгрөгийн орлогын 16 гүйлгээг, 585.5 сая төгрөгийн зарлагын 40 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн;
- Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГХЗ: Шилэн дансны цахим хуудсанд жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт 536.6 сая төгрөг, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 5.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 80.5 сая төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 5.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө, мөнгө зарцуулах 11.9 сая төгрөгийн 8 шийдвэрийг байршуулаагүй;
- Зэд-Хантай-Бүтээлийн нурууны ДЦГХЗ: Шилэн дансанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн шийдвэрийг, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын нийт 879.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй;
- Хөх сэрхийн нурууны УТХГХЗ: Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 564.1 сая төгрөгийн 29 гүйлгээ мэдээлээгүй;
- Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 543.5 сая төгрөгийн 14 гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 7 шийдвэрийг, мөн байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд шууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тус тус байршуулаагүй;
- Хөгнө Тарнын БЦГХЗ: Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 510.2 сая төгрөгийн 14 гүйлгээг мэдээлээгүй;
- Ачит нуур Дэвэл арлын БЦГХЗ: Шилэн дансанд 364.1 сая төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан;
- Онон Улз сав газрын захиргаа: Шилэн дансны цахим хуудсанд 351.2 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан;
- Бөөнцагаан нуур-Орог нуурын сав газрын захиргаа: Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлогын 120.2 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй;
- Баян-Өлгий аймгийн УЦУОШТ: Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 35.6 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй;
- Өвөрхангай аймгийн УЦУОШТ: Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш орлогын 18 гүйлгээ, зарлагын 6 гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулсан 4 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан;
- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ: Шилэн дансны цахим хуудсанд төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, дараа жилийн зорилтот түвшин, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаанд нь мэдээлээгүй;
- Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа: Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайлан, төсвийн төсөл, батлагдсан төсөв зэрэг мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй;
- Сэлэнгэ голын сав газрын захиргаа: Шилэн дансанд бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 4 тушаалыг мэдээлээгүй;
- Ойн газар: Шилэн дансны цахим системд байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг оруулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зөвлөмж

1. Үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны өөрийн эзэмшлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Наран хотхоны 21В байрны 3 давхрын 121.8 м.кв талбайг 2008 онд нийт 238.7 сая төгрөгөөр худалдан авсан боловч үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхийн гэрчилгээг аваагүй байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т "Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 5.1-д заасан өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэснийг нотолж эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус байгууллагын өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхийн гэрчилгээг авах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах, зөрчлийг арилгах.

2. Тусгай хамгаалалттай нутагт газар ашиглахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: БОУАӨС-ын тушаалаар "Тусгай хамгаалалттай нутагт газар эзэмших эрхийг хянан шийдвэрлэх зөвлөл"-ийн шийдвэрийг үндэслэн нийт 281,258.0 м.кв талбайтай ашиглаж байгаа газраа иргэн, ААНБ нь бусдад шилжүүлж, 228,483.5 м.кв талбайг сонгон шалгаруулалтгүй нэмж олгосон байна.

Энэ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 12-т "Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.18-д зааснаар тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрлийг мөн хуулийн 5.6 дугаар зүйлийн 1-д заасны дагуу сонгон шалгаруулалтаар олгох", 39 дүгээр зүйлийн 1-д "Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн, нэгж, байгууллага дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 1-д "ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулах", 42 дугаар зүйлийн 42.1-д "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина", Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 23.2.4-т "улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Тусгай хамгаалалттай нутагт газар ашиглахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2025 оны "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-нд 2 удаа өөрчлөлт оруулж, тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж болох газар нутгийн хэмжээг 101.3 га болгон өөрчилж, анх баталснаас 18.1 га талбайгаар нэмэгдүүлсэн, мөн батлагдсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлээгүй байна.

Энэ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-т "Энэ зүйлийн 2-т заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлагдсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлнэ", Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 23.2.4-т "улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлагдсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа: Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам батлагдаагүйгээс шинээр барьсан Манзуширын аманд байрлах 72.0 м.кв талбайтай 172.4 сая төгрөгийн, Жаргалантын аманд байрлах 59.59 м.кв талбайтай 44.3 сая төгрөгийн, нийт 216.7 сая төгрөгийн өртөгтэй судалгаа шинжилгээний төвийн болон байгаль хамгаалагчийн байрыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн боловч өмчлөх эрхийн гэрчилгээг аваагүй байна.

Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т "Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 5.1-д заасан өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэснийг нотолж эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус байгууллагын өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхийн гэрчилгээг авах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах, зөрчлийг арилгах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шалгагдагч байгууллагын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийж гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн өмнөх аудитаар алдаа зөрчлийг арилгах 8,850.9 сая төгрөгийн 5 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлснээс, хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Хүснэгт 12. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	8,850.9	3	8,850.9	60.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	-	1	-	100.0
Дүн	6	8,850.9	4	8,850.9	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараах асуудлуудыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар анхаарч горим сорил гүйцэтгэх шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал:

1. ЦУОШГ-ын харьяа Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд хэрэгжүүлж байгаа "Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хамтарсан гэрээт ажил"-ын гүйцэтгэл, үр дүнг анхаарах;
2. Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын өмнөх онуудад болон тайлант онд үссэн цахилгааны болон нийгмийн даатгалын шимтгэл, татварын өрийн нийт 771.4 сая төгрөгийн өрийг хэрхэн барагдуулсан эсэх;
3. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний үр дүнг дүгнээгүй, дуусаагүй асуудал давтагдан гарч байхад ижил төстэй арга хэмжээг хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлж гүйцэтгэсэн эсэх;
4. Туулын хурдны замын төслийг хэрэгжүүлэгч Хаоюань Женерал Констракшн ГХО ХХК нь Байгаль орчны төлөвлөгөөнд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх баталгааг байршуулсан болон бусад төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлсэн эсэх;

5. Засгийн газрын 2025 оны 242 дугаар “Тусгай зориулалтаар 2025 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай “ тогтоолоор нэр бүхий 10 аймагт спорт болон олдворын зориулалтаар агнах, барих 9 төрлийн болон бусад амьтан 5341, нэр бүхий 6 аймагт соёлын зориулалтаар угалз 11, тэх 6 ширхгийг агнахаар баталсан ба тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан эсэх, төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлдэг эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 4,964.9 сая төгрөгийн 109 алдаа илэрснээс аудитын явцад 3,843.8 сая төгрөгийн 103 алдааг залруулж, 959.5 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 161.7 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 31,813.6 сая төгрөгийн 151 зөрчил илэрснээс, 374.4 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 11,791.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 52 албан шаардлага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 14.4 сая төгрөгийн 3 албан шаардлагыг хүргүүлж, 19,633.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 65 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 31,813.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 29,022.6 сая төгрөгөөр хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 94 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 49 байгууллагад бие даан дүгнэлт гаргаж, 45 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Харьяа 43 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 5 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 36,219.1 сая төгрөгийн 256 алдаа, зөрчил илэрсэнд 3,807.4 сая төгрөгийн 102 алдааг аудитын явцад залруулж, 374.4 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 12,750.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 53 албан шаардлага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 14.5 сая төгрөгийн 3 албан шаардлагыг хүргүүлж, 19,795.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 70 зөвлөмжийг өгсөн байна. Мөн 1,577.5 сая төгрөгийн 3 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тохируулгын тайланд 36.4 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн орлогын тохируулгыг зөрүүтэй тусгасан алдааг аудитын явцад залруулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”-ийн 5.1.2-т “тасралтгүй байх”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт: 1. Байгаль орчны мэдээллийн сангаас бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, хайгуул, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлдэг томоохон 34 төрийн болон хувийн өмчит хуулийн этгээдийг түүвэрлэн 2023-2025 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх баталгааны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган шалгахад нийт 691.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. “Оюутолгой” ХХК нь 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөхөн сэргээлтийн баталгааг байршуулаагүй байхад 2024 оны төлбөрийн баримтыг хавсаргаж 2026 оны 4 дүгээр сарын 20-нд баталсан;
2. “Цагаан Өвөлжөө” ХХК 2025 онд 20.0 сая төгрөгийг нөхөн сэргээлтийг баталгааг байршуулаагүй байхад нэхэмжлэхийн баримтыг хавсарган менежментийн төлөвлөгөөг баталсан;
3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байршуулах нөхөн сэргээлтийн баталгааг 2023 онд “Оюутолгой” ХХК 650.4 сая төгрөг, 2025 онд “Юбиксолюшн” ХХК 9.7 сая төгрөг, “Өсөх зоос” ХХК 11.5 сая төгрөг, нийт 671.6 сая төгрөгийг дутуу байршуулсан боловч менежментийн төлөвлөгөөг баталсан;

4. Тайлант 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаар төрийн өмчит 7, орон нутгийн өмчит 1, хувийн өмчит 7, нийт 15 аж ахуйн нэгж байгууллага нь 2025 оны 8-12 дугаар сард илгээснээс, 12 төлөвлөгөөг баталж, 2 төлөвлөгөөг буцааж, 1 төлөвлөгөөг хуваарилсан төлөвтэй байгаа;
5. Байгаль орчны мэдээллийн санд менежментийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг цахимаар тайлагнадаг боловч нөхөн сэргээлтийн баталгааны 2007 оноос хойш хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг цахим сангаас нэгтгэлээр гаргах боломжгүй, холбогдох ажилтнууд "excel" файлаар хөтөлж байна.

Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д "Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана", 9.10-т "Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн БОУАӨС-ын 2025 оны А/38 дугаар тушаалаар баталсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 1.2-т "Бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, ашиглалтын хайгуул, баяжуулах боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдахаас өмнө байршуулна", 2.1-д "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу төвлөрүүлнэ" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50.0 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдахаас өмнө нөхөн сэргээлтийн тусгай дансанд бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох, нөхөн сэргээлтийн баталгааг бүрэн байршуулах, байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн бүртгэлийг цахим системд оруулах, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

Илрүүлэлт: 2. БОУАӨС-ын эрхлэх асуудлын хүрээний 94 байгууллага аудитад хамрагдаж, 49 байгууллагад дүгнэлт өгснөөс, 5 байгууллага "хязгаарлалттай", 1 байгууллага "Сөрөг" дүгнэлт авсан, мөн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 31,813.6 сая төгрөгийн 151 зөрчил илэрсэн ба өмнөх оноос зөрчлийн дүн 1.7 дахин өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сайдын эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг эрчимжүүлэх, алдаа зөрчлийг арилгах, таслан зогсоох, Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг 60-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авчавч, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.2.2 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ХБНГУ-ын Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл I /KFW/-ийн хүрээнд хэрэгжүүлсэн “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан”-ийн холбогдох гэрээний хугацаа дуусгавар болсон тул Төрийн банканд байршуулсан эх үүсвэрийн нийт үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, холбогдох байгууллагатай зөвшилцөж эцэслэн шийдвэрлээгүй, зөвхөн харилцах дансны үлдэгдэл 1,075.5 сая төгрөгийг данс бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн банканд байршуулсан эх үүсвэрийн нийт үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан, холбогдох байгууллагатай зөвшилцөж эцэслэн шийдвэрлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус яамны түрээсэлж байсан Засгийн газрын 12 дугаар байрны 4 давхрын их засварын зардалд нийт 518.1 сая төгрөгийг зарцуулсан боловч тус байрнаас нүүж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн байранд их засвар хийхгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авч, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын татан буулгахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх онуудад татан буугдсан 2 ТӨААТҮГ-ын хаалтын балансыг гаргаагүй, нийт 4.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

1. Монгол-Ус ТӨААТҮГ-ыг татан буулгаж хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг Усны газарт шилжүүлэхээр тогтоосон боловч Санхүүгийн байдлын тайланд 1.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн, 3.5 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдэлтэй;
2. Аялал жуулчлалын хөгжлийн төвийн арилжааны банкин дахь харилцах дансанд 10,823.68 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 243 дугаар тогтоолоор “Монгол-Ус” ТӨААТҮГ-ыг татан буулгаж хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг Усны газарт шилжүүлэх” тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй, Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ыг татан буулгаж, хаалтын баланс гаргах, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг бүртгэж авах талаар хуульд заасан арга хэмжээ авахыг ТӨБЗГ-т даалгасан” боловч тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨААТҮГ-ыг татан буулгаж, хаалтын баланс гаргах, тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллах.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оноос хойш салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн

хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулж, батлуулах арга хэмжээг авах, үүнтэй холбоотой төсвөөс нэмэлт зардал гаргахгүй байх.

5.3 Түүврийн байгууллага

Түүврийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 415.3 сая төгрөгийн алдаа илэрсэн ба аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Байгаль орчин судалгаа шинжилгээний төв: Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд эхний үлдэгдэлгүй буюу дахин үнэлгээний нэмэгдэлгүй байхад тайлант онд хасах 6.3 сая төгрөгийг бүртгэсэн, мөн төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 25.6 сая төгрөгийг тохируулах бичилт хийгээгүй;
2. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа: Мөнгөн гүйлгээний тайланд бие ба биет бус хөрөнгө худалдан авсан 15.3 сая төгрөгийн бүртгээгүй;
3. Туул голын сав газрын захиргаа: Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн 23.4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоор бүртгэсэн, мөн хандив тусламжаар ирсэн үндсэн хөрөнгийн 38.5 сая төгрөгийг гадаад хандив тусламжийн дансанд бүртгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 67.5 сая мянган төгрөгийг орлогоор бүртгэсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 67.5 сая төгрөгийг тохируулаагүй, төсвийн санхүүжилтийг 64.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан;
4. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа: Мөнгөн гүйлгээний тайланд бие ба биет бус хөрөнгө худалдан авсан 39.5 сая төгрөгийн бүртгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 60.6 сая төгрөгийг тохируулах бичилт хийгээгүй;
5. Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв: Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн 7.0 сая төгрөгийг бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.2-т "тасралтгүй байх", 5.1.4-т "үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3.1 Албан шаардлага

Илрүүлэлт:1 Тус яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 5,057.0 м.кв, 44,773.0 м.кв, нийт 49,830.0 м.кв буюу 4.9 га газрыг ашиглах эрхийг 5 жилийн хугацаатай хязгаарлалтын бүсэд олгосон боловч данс бүртгэлд тусгаагүй байна. Мөн татвар төлсөн газрын төлбөрийн тооцоогоор нийт 10 газрын төлбөрийг төлсөн боловч биет бус хөрөнгийн дансанд 4 газрыг бүртгэж, 6 газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байрлах, ашиглах эрхтэй 6 газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Илрүүлэлт: 2. Тус яамны харьяа “Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв” УТҮГ-т Богдхан уулын дархан цаазат газрын Жаргалантын амны хязгаарлалтын бүсэд байрлах 30424.0 м.кв буюу 3.0 га газрыг, Зайсангийн аманд байрлах 4001.2 м.кв буюу 0.4 га газрыг ашиглах эрхийг тус тус 5 жилийн хугацаатай олгосон боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байрлах, ашиглах эрхтэй нийт 3.4 га газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.3.2 Зөвлөмж

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 13 байгууллагын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 5 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгаль орчин, уур амьсгалын санд гэмт хэргийн улмаас шүүхийн шийдвэрээр хураан авсан эд зүйлсийг хүлээлгэн өгсөн гэх боловч цаашид асуудлыг хэрхэн шийдвэрлэх хугацаа тодорхойгүй, зарим эд зүйлсийг ашиглах боломжгүй болсон, аль ч байгууллагад бүртгэлгүй, агуулахын бүртгэлээр 9 нэрийн хураагдсан барааны дараах үлдэгдэлтэй байна. Үүнд:

1. "Nissan Advan" маркийн гэх Mazda үйлдвэрийн логотой цагаан өнгийн 6408 УБО улсын дугаартай автомашин;
2. Бөхөнгийн эвэр 2671 ширхэг;
3. Хонин арц 55 шуудай;
4. Хуш модны самар 17 шуудай, самрын хог 3 шуудай;
5. Дэрвэгэр жиргэрүү 502.5 кг.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д "төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах", 2-т "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 09-ны өдрийн 171 дүгээр тогтоолын 3-т "Байгаль орчин, уур амьсгалын сангийн Ажлын албаны хаалтын балансыг гаргах, ..., бусад холбогдох тооцоог хийхийг Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдад даалгасугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Богдхан уулын ДЦГХЗ-ны хөрөнгөд бүртгэлтэй, өөрийн эзэмшлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Арцатын 17 гудамж, 17-2 тоотод байрлах 850 м.кв газарт 80 айлын орон сууцны барилга бариулахаар “Глобал бридж констракшн” ХХК-тай "Хөрөнгө оруулж, хамтрах ажиллах гэрээ"-г байгуулж, гэрээнд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны болон өөрийн байгууллагын ажилчдын хэрэгцээнд зориулж 12 орон сууцыг актаар хүлээн авсан боловч асуудлыг шийдвэрлээгүй, тус байрны СӨХ-өөс 15.0 сая төгрөгийн ашиглалтын зардлын төлбөрийг нэхэмжилсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ажилчдын хэрэгцээнд зориулж 12 орон сууцыг актаар хүлээн авсан боловч асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх.

3. Орлогын төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөгөөгүйгээс 100.8 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 737.5 сая төгрөгөөр буюу 731.0 хувиар биелүүлж давсан орлогод 636.7 сая төгрөгийг хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Орлогын төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөгөөгүйгээс 29.0 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 198.3 сая төгрөгөөр буюу 683.0 хувиар биелүүлж давсан орлогод 169.3 сая төгрөгийг хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй нийт 487.7 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, холбогдох эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Булган аймгийн УЦУОШТ	3	3.9	3	3.9			3	3.9						
2	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	1	4.2			1	4.2	1	4.2						
3	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	5.4	1	5.4			1	5.4						
4	Дорноговь аймгийн УЦУОШТ	1	2.3			1	2.3	1	2.3						
5	Дундговь аймгийн УЦУОШТ	1	1.5	1	1.5			1	1.5						
6	Төв аймгийн УЦУОШТ	2	127.4	1	38.0	1	89.4	2	127.4						
7	Увс аймгийн УЦУОШТ	2	1.3	2	1.3			2	1.3						
8	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	1	0.1	1	0.1			1	0.1						
9	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	1	141.6			1	141.6	1	141.6						
10	Ховд аймгийн УЦУОШТ	4	164.1	1	37.9	3	126.2	4	164.1						
11	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	3	36.6			3	36.6	3	36.6						
12	Өмнөговь аймгийн УЦУОШТ	2	0.4			2	0.4	2	0.4						
13	Цаг уур, орчны шинжилгээний газрын нэгтгэсэн тайлан	3	811.9	1	40.0	2	771.9	2	771.9	1	40.0	1	40.0		
14	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	2	0.8	1	0.8	1		2	0.8						
15	Бөөнцагаан нуур-Орог нуурын сав газрын захиргаа	1	12.1			1	12.1	1	12.1						
16	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	6	68.0	2	38.5	4	29.5	6	68.0						
17	Орхон-Чулуут сав газрын захиргаа	1	0.3			1	0.3	1	0.3						
18	Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаа	3	1.6	3	1.6			3	1.6						
19	Туул голын сав газрын захиргаа	3	260.9			3	260.9	3	260.9						
20	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа	2	20.8	1	16.8	1	4.0	2	20.8						
21	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа	1	12.2			1	12.2	1	12.2						
22	Говь гурвансайханы БЦГХЗ	4	27.3	2	24.6	2	2.7	4	27.3						
23	Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	2	19.2			2	19.2	2	19.2						
24	Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа	3	332.0	1	160.2	2	171.8	3	332.0						
25	Их газрын чулууны БЦГХЗ	3	69.9	2	2.6	1	67.3	3	69.9						
26	Мянган угалзатын БЦГХЗ	3	13.2	1	4.4	2	8.9	3	13.2						
27	Ноён уулын ДЦГХЗ	3	14.2	1	12.6	2	1.5	3	14.2						
28	Нөмрөгийн ДЦГХЗ	3	38.5			3	38.5	3	38.5						
29	Онон балжийн БЦГХЗ	1	20.6			1	20.6	1	20.6						
30	Орхоны хөндийн БЦГХЗ	1	2.9			1	2.9	1	2.9						
31	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа	1	148.0			1	148.0	1	148.0						
32	Увс нуурын ай савын УТХГНХЗ	2	4.0	1	0.3	1	3.7	2	4.0						
33	Хангайн нурууны БЦГХЗ	1	61.4			1	61.4	1	61.4						
34	Хан Хөхийн нурууны УТХГНХЗ	3	4.8			3	4.8	3	4.8						
35	Хан Хэнтийн УТХГХЗ	2	100.0			2	100.0	2	100.0						
36	Хар ус нуур орчмын УТХГНХЗ	1	5.5			1	5.5	1	5.5						

37	Хөх сэрхийн нурууны УТХГХЗ	2	23.4			2	23.4	2	23.4						
38	Хөгнө Тарнын БЦГХЗ	5	154.1	2	88.8	3	65.3	4	122.7	1	31.4	1	31.4		
39	Хөвсгөлийн Улаан тайгын УТХГХЗ	4	27.8			4	27.8	4	27.8						
40	Хөвсгөлийн УТХГХЗ	3	393.1			3	393.1	3	393.1						
41	Хэрлэн голын сав газрын захиргаа	2	1.0	2	1.0		0.0	2	1.0						
42	БОУАӨЯ ТШЗ	2	1,049.6			2	1,049.6			2	1,049.6	1	90.2	1	959.5
43	Ойн газар	1	276.0	1	276.0		0.0	1	276.0						
44	Усны газар	7	425.4	3	34.8	4	390.6	7	425.4						
45	Байгаль орчин, судалгаа шинжилгээний төв	2	31.9			2	31.9	2	31.9						
46	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ	2	0.1			2	0.1			2	0.1	2	0.1		
47	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ	1	7.0	1	7.0		0.0	1	7.0						
48	БОУАӨЯ ТЕЗ	1	36.4			1	36.4	1	36.4						
	Дүн	109	4,964.9	35	798.2	74	4,166.8	103	3,843.8	6	1,121.2	5	161.7	1	959.5

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл															
		Нийт зөрчил		Үүнээс												Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага							
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн			
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13			
1	Архангай аймгийн УЦУОШТ	1				1											
2	Булган аймгийн УЦУОШТ	2	5.3	1	0.9			1	4.3								
3	Баянхонгор аймгийн УЦУОШТ	2	1.0			2	1.0										
4	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	1	8.2					1	8.2								
5	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	1.4			1	1.4										
6	Дархан-Уул УЦУОШТ	2	1.7	1	0.4	1	1.3										
7	Дорнод аймгийн УЦУОШТ	3	2.8	3	2.8												
8	Дорноговь аймгийн УЦУОШТ	5	341.8	1	1.2	1	0.5	3	340.1								
9	Дундговь аймгийн УЦУОШТ	2	57.8	1	1.5			1	56.3								
10	Төв аймгийн УЦУОШТ	1	22.7					1	22.7								
11	Орхон аймгийн УЦУОШТ	1	1.0					1	1.0								
12	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	1	90.0					1	90.0								
13	Ховд аймгийн УЦУОШТ	2	0.9					2	0.9								
14	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	4	8.7					4	8.7								
15	Өмнөговь аймгийн УЦУОШТ	4	14.7			2	2.3	1		1	1	12.5					
16	Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	1	34.2					1	34.2								
17	Цаг уур, орчны шинжилгээний газар/ТШЗ/	1	15.6					1	15.6								
18	Цаг уур, орчны шинжилгээний газрын нэгтгэсэн тайлан	1	12.6	1	12.6												
19	Богдхан уулын ДЦГХЗ	2	-			1	-	1									
20	Говийн их ДЦГ-ын А хэсгийн хамгаалалтын захиргаа	3	6.7					2	6.7	1	1	-					
21	Говийн их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргаа	1	7.0			1	7.0										
22	Горхи тэрэлжийн БЦГХЗ	2	15.3			1		1	15.3								
23	Зэд-Хантай-Бүтээлийн нурууны ДЦГХЗ	2	1.0	2	1.0												
24	Их богдын БЦГХЗ	2	-			1	-	1									
25	Их газрын чулууны БЦГХЗ	1	29.0					1	29.0								
26	Монгол элсний УТХГНХЗ	1	0.2	1	0.2												
27	Мянган угалзатын БЦГХЗ	2	1.3	1	1.3			1									
28	Ноён уулын ДЦГХЗ	1	0.7			1	0.7										
29	Нөмрөгийн ДЦГХЗ	3	4.9	2	4.7			-	1	0.2							
30	Орхоны хөндийн БЦГХЗ	1	1.4			1	1.4										
31	Тужийн нарсны БЦГХЗ	1	9.6					1	9.6								
32	Тэсийн гол, Булнайн нурууны БЦГХЗ	3	66.6	1	0.4			2	66.2								
33	Увс нуурын ай савын УТХГНХЗ	1	0.5					1	0.5								
34	Хан Хэнтийн УТХГХЗ	1	-			1	-										
35	Хар ус нуур орчмын УТХГНХЗ	1	6.0					1	6.0								
36	Хөгнө Тарнын БЦГХЗ	1	1.1	1	1.1												

37	Хөвсгөлийн Улаан тайгын УТХГХЗ	3	21.6					3	21.6					
38	Хөвсгөлийн УТХГХЗ	3	18.2	1	0.4			2	17.8					
39	Хөх сэрхийн нурууны УТХГХЗ	2	35.0	1	0.5			1	34.5					
40	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	2	6.2	1	1.3			1	4.9					
41	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	3	17.1					3	17.1					
42	Онги-Таац голын сав газрын захиргаа	1	28.3			1	28.3							
43	Онон Улзын сав газрын захиргаа	1	9.3					1	9.3					
44	Орхон-Чулуутын сав газрын захиргаа	3	0.6	2	0.6	1	-							
45	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	2	4.8	2	4.8									
46	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа	1	0.7	1	0.7									
47	Хануй голын сав газрын захиргаа	1	3.4					1	3.4					
48	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа	2	3.1			1	1.6	1	1.5					
49	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа	1	8.1			1	8.1							
50	Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа	1	27.4					1	27.4					
51	Хэрлэн голын сав газрын захиргаа	1	1.1	1	1.1									
52	БОУАӨЯ	21	15,113.9	3	331.9	14	9,658.9	4	5,123.1			2	1,576.9	
53	Ойн газар	12	12,848.4	1	1.8	6	417.9	5	12,428.7					
54	Усны газар	8	835.7	1	3.2	2	192.7	5	639.8					
55	Монгол кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ	3	775.4			3	775.4							
56	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ	8	3.2	1	0.0	6	1.2			1	1	2.0	1	0.5
57	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ	2				1	-	1	-					
58	Байгаль орчин, судалгаа шинжилгээний төв	1	65.8					1	65.8					
59	Байгаль орчин, уур амьсгалын сан	1						1	-					
60	Нөхөн сэргээлтийн баталгаа	1	691.6			1	691.6							
61	БОУАӨЯ ТЕЗ	3	523.0					3	523.0					
	Дүн	151	31,813.6	31	374.4	52	11,791.3	65	19,633.5	3	3	14.5	3	1,577.5

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
А	Б	1	2	3	4	5	6	7	8
	<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
1	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	1	35.6					1	35.6
2	Дархан-уул УЦУОШТ	1	64.5					1	64.5
3	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	1	-					1	-
4	Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний төв	1	340.3					1	340.3
5	Цаг уур, орчны шинжилгээний газар ТШЗ	1	291.9					1	291.9
6	Нислэгийн цаг уурын төв	1	229.0					1	229.0
7	Хөх сэрхийн нурууны Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын Захиргаа	1	564.1					1	564.1
8	Бөөнцагаан нуур-Орог нуурын сав газрын захиргаа	1	120.2			1	120.2		
9	Хөгнө Тарнын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа	1	69.0					1	69.0
10	Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	1	879.8					1	879.8
11	Нөмрөгийн Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	1	7.2			1	7.2		
12	Онон Улз сав газрын захиргаа	1	351.2					1	351.2

13	Онги-Таац голын сав газрын захиргаа	1						1	-
14	Ноён уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	1						1	-
15	Увс нуурын ай савын УТХГН-ийн хамгаалалтын захиргаа	1	543.5					1	543.5
16	Ачит нуур Дэвэл арлын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	364.1					1	364.1
17	Хөвсгөлийн Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	1						1	-
18	Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа	1						1	-
19	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	1						1	-
20	Гутайн даваа-Хөмүүл голын эхийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	638.9			1	638.9		
21	Хараа-Ерөө голын сав газрын захиргаа	1	18.5					1	18.5
22	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	1						1	-
23	Туул голын сав газрын захиргаа	1	339.0			1	339.0		
24	Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа	1	256.2					1	256.2
25	Горхи тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	1	78.5					1	78.5
26	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв	1	1,227.4			1	1,227.4		
27	Ойн газар	1				1	-		
28	Усны газар	1	1,736.9			1	1,736.9		
29	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ	1						1	-
30	Байгаль орчин судалгаа шинжилгээний төв	1	142.3					1	142.3
	Дүн	30	8,298.2			8	4,420.8	22	3,877.4
	<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
1	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	1	0.7	1	0.7				
2	Усны газар	3	10,685.8			3	10,685.8		
3	Ойн газар	2	38.5			1	37.9	1	0.6
4	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	2	23.8					2	23.8
5	Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	1	0.2			1	0.2		
6	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	14.3					1	14.3
7	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ	1	0.0					1	0.0
8	Цаг уур, орчны шинжилгээний газар ТШЗ	1				1	-		
9	Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа	1						1	-
10	Буйр нуур Мэнэнгийн сав газрын захиргаа	1						1	-
11	БОУАӨЯ	1				1	-		
12	Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	4	216.7					4	216.7
13	БОУАӨЯ ТЕЗ	2	-			1	-	1	-
	Дүн	21	10,979.9	1	0.7	8	10,723.9	10	255.3
	НИЙТ ДҮН	51	19,278.1	1	0.7	16	15,144.7	32	4,132.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1401/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026 / 2 / ИА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчны мэдээллийн сангаас бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, хайгуул, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон хувийн өмчит 34 хуулийн этгээдийг түүвэрлэн 2023-2025 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх баталгааны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тулган шалгахад нийт 691.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. "Оюутолгой" ХХК нь 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөхөн сэргээлтийн баталгааг байршуулаагүй байхад 2024 оны төлбөрийн баримтыг хавсаргаж 2026 оны 4 дүгээр сарын 20-нд баталсан;
2. "Цагаан Өвөлжөө" ХХК 2025 онд 20.0 сая төгрөгийг нөхөн сэргээх баталгааг байршуулаагүй байхад нэхэмжлэхийн баримтыг хавсарган менежментийн төлөвлөгөөг баталсан;
3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байршуулах нөхөн сэргээлтийн баталгааг 2023 онд "Оюутолгой" ХХК 650.4 сая төгрөг, 2025 онд "Юбиксолюшн" ХХК 9.7 сая төгрөг, Өсөх зоос ХХК 11.5 сая төгрөг, нийт 671.6 сая төгрөгийг дутуу байршуулсан боловч менежментийн төлөвлөгөөг баталсан;
4. Тайлант оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаар төрийн өмчит 7, орон нутгийн өмчит 1, хувийн өмчит 7, нийт 15 аж ахуйн нэгж байгууллага нь 2025 оны 8 дугаар сараас 12 дугаар сард илгээснээс, 12 төлөвлөгөөг баталж, 2 төлөвлөгөөг буцааж, 1 төлөвлөгөөг хуваарилсан төлөвтэй байгаа;
5. Байгаль орчны мэдээллийн санд менежментийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг цахимаар тайлагнадаг боловч нөхөн сэргээлтийн баталгааны 2007 оноос хойш хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг цахим сангаас нэгтгэлээр гаргах боломжгүй, холбогдох ажилтнууд эксел файлаар хөтөлж байна.

Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д "Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана", 9.10-т "Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл

хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/38 дугаар тушаалаар баталсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 1.2-т "Бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, ашиглалтын хайгуул, баяжуулах боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдахаас өмнө байршуулна", 2.1-д "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу төвлөрүүлнэ" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зарим төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50.0 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдахаас өмнө нөхөн сэргээлтийн тусгай дансанд бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох, байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн бүртгэлийг цахим системд оруулах, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд /Ц.Сандаг-Очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Ч.Чулуунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1402/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 31,813,642,100.00 /гучин нэгэн тэрбум найман зуун арван гурван сая зургаан зуун дөчин хоёр мянган нэг зуун/ төгрөгийн 151 зөрчил илэрсэн ба зөрчлийн дүн өмнөх оноос 1.7 дахин өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 15 дугаар зүйлийн 15.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.10, 42 дугаар зүйлийн 42.1, 42.5 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд /Ц.Сандаг Очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Ч.Чулуунчимэг/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shoardlaga 2026.04.24 SAG-27 Docx

1526182165



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1377/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 5,057.0 м.кв, 44,773.0 м.кв, нийт 49,830.0 м.кв буюу 4.9 га газрыг ашиглах эрхийг 5 жилийн хугацаатай хязгаарлалтын бүсэд олгосон боловч данс бүртгэлд тусгаагүй байна. Мөн татвар төлсөн газрын төлбөрийн тооцоогоор нийт 10 газрын төлбөрийг төлсөн боловч биет бус хөрөнгийн дансанд 4 газрыг бүртгэж, 6 газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих есоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байрлах, ашиглах эрхтэй 6 газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Богдхан уулын дархан цаазат газрын Хамгаалалтын захиргааны дарга /Э.Цогбадрал/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Олонбаяр/ нэрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Д.БАЯРСАЙХАН
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga 2026\0424 SAG-26.Docx

1526182154



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1378/А0160066

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТЕЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Туул голын сав газрын захиргаа нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 339,018,400.00 /гурван зуун гучин есөн сая арван найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн 7 гүйлгээ болон бусад 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Туул голын сав газрын захиргааны дарга /С.Хан-уул/, ерөнхий нягтлан бодогч /Д.Ариунаа/нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Д.БАЯРСАЙХАН
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Г.САМПИЛМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga-2026\0424 SAC-26 Docx

1526182156



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1380/А0160066

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-т Богдхан уулын дархан цаазат газрын Жаргалантын амны хязгаарлалтын бүсэд байрлах 30,424.0 м.кв буюу 3.0 га газрыг, Зайсангийн аманд байрлах 4,001.2 м.кв буюу 0.4 га газрыг ашиглах эрхийг тус тус 5 жилийн хугацаатай олгосон боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байрлах, ашиглах эрхтэй нийт 3.4 га газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-ын захирал /Г.Ууганхүү/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Д.БАЯРСАЙХАН
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Г.САМПИЛМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga'20260424 SAC-26.Docx

1526182158



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1379/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны харьяа Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,125,492,645.00 /нэг тэрбум нэг зуун хорин таван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга зургаан зуун дөчин таван/ төгрөгийн 18 гүйлгээ, зарлагын 101,932,100.00 /нэг зуун нэг сая есөн зуун гучин хоёр мянга нэг зуун/ төгрөгийн 13 гүйлгээ болон бусад 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-ын захирал /Г.Ууганхүү/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Д.БАЯРОЙХАН
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Г.САМПИЛМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрны 3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026/0424 SAG-26.Docx

1526182160